技能実習生手帳

Ур чадварын дадлагажигч нарт зориулсан гарын авлага

（第10版）



モンゴル語版

Монгол хэл дээрх хувилбар

アプリ版は以下のＱＲコードからダウンロードできます。

Аппликэйшин хувилбарыг та доорх QR кодоос татаж авах боломжтой.



＜iPhoneをお使いの方はこちら＞

<Хэрэв та iPhone ашиглаж байгаа бол энд дарна уу.>



＜Androidをお使いの方はこちら＞

<Хэрэв та Android ашиглаж байгаа бол энд дарна уу.>

外国人技能実習機構

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага

OTIT

母国語相談ホットライン　11:00～19:00（月～金）
9:00～17:00（土、日）

ベトナム語	毎週: 月曜日～金曜日・土曜日	TEL: 0120-250-168
中国語	毎週: 月曜日・水曜日・金曜日	TEL: 0120-250-169
インドネシア語	毎週: 火曜日・木曜日・土曜日	TEL: 0120-250-192
フィリピン語	毎週: 火曜日・木曜日・土曜日	TEL: 0120-250-197
英　語	毎週: 火曜日・木曜日・土曜日	TEL: 0120-250-147
タイ語	毎週: 木曜日・日曜日	TEL: 0120-250-198
カンボジア語	毎週: 木曜日	TEL: 0120-250-366
ミャンマー語	毎週: 火曜日	TEL: 0120-250-302

※通話料は無料です。

外国人技能実習機構（OTIT）

※点線に沿って切り取り、パスケース等に入れておいてください。

外国人技能実習機構地方事務所・支所相談窓口
毎週: 月曜日～金曜日 9:00～17:00

※祝日・年末年始（12月29日～1月3日）はお休みです。
※通訳人が必要な場合については、相談開始にお時間をいただく場合があります。

札幌事務所	：0120-163-417	仙台事務所	：0120-163-418
水戸支所	：0120-163-419	東京事務所	：0120-163-420
長野支所	：0120-163-421	名古屋事務所	：0120-163-422
富山支所	：0120-163-423	大阪事務所	：0120-163-424
広島事務所	：0120-163-425	高松事務所	：0120-163-426
松山支所	：0120-163-427	福岡事務所	：0120-163-428
熊本支所	：0120-163-429		

※通話料は無料です。

外国人技能実習機構（OTIT）

※点線に沿って切り取り、パスケース等に入れておいてください。

Эх хэл дээрх зөвлөгөө өгөх утасны үйлчилгээ 11:00-19:00 (Даваа гараг-Баасан гараг)
9:00-17:00 (Бямба гараг, Ням гараг)

Вьетнам хэл	Долоо хоног бүрийн Даваа-Баасан гараг, Бямба гараг Утасны дугаар: 0120-250-168
Хятад хэл	Долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гараг Утасны дугаар: 0120-250-169
Индонез хэл	Долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв, Бямба гараг Утасны дугаар: 0120-250-192
Филиппин хэл	Долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв, Бямба гараг Утасны дугаар: 0120-250-197
Англи хэл	Долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв, Бямба гараг Утасны дугаар: 0120-250-147
Тайланд хэл	Долоо хоног бүрийн Пүрэв, Ням гараг Утасны дугаар: 0120-250-198
Камбож хэл	Долоо хоног бүрийн Пүрэв гараг Утасны дугаар: 0120-250-366
Мьянмар хэл	Долоо хоног бүрийн Мягмар гараг Утасны дугаар: 0120-250-302

* үнэгүй дуудлага хийнэ.

Гадаад иргэдийн ур чадварын байгууллага (OTIT)

* Цэгэн зураасаар хайчлан авч, билетний сав болон гялгар уутанд хийж хадгална уу.

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагын орон нутгийн газар, салбарын зөвлөгөө өгөх газар

Долоо хоног бүр: Даваа-Баасан гараг 9:00 - 17:00

* Баярын амралтын өдрүүд, жилийн эцэс, жилийн эхний (12 сарын 29 – 1 сарын 3) өдрүүдэд амарна.
* Орчуулагч шаардлагатай бол зөвлөгөө эхлэхийн тулд хүлээлгэх тохиолдол гардаг.

Саппоро оффис	: 0120-163-417	Сэндай оффис	: 0120-163-418
Мито салбар	: 0120-163-419	Токио оффис	: 0120-163-420
Нагано салбар	: 0120-163-421	Нагоя оффис	: 0120-163-422
Тояма салбар	: 0120-163-423	Осака оффис	: 0120-163-424
Хирошима оффис	: 0120-163-425	Такамацү оффис	: 0120-163-426
Мацүяма салбар	: 0120-163-427	Фүкүока оффис	: 0120-163-428
Күмамото салбар	: 0120-163-429		

Гадаад иргэдийн ур чадварын байгууллага (OTIT)

* Цэгэн зураасаар хайчлан авч, билетний сав болон гялгар уутанд хийж хадгална уу.

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага Эх хэл дээр зөвлөгөө өгөх утас

- Ажлын дээрээ эсвэл өдөр тутмын амьдралд аливаа асуудал, сэтгэл түгшээх зүйл гарвал
- Цалин хөлс, илүү цагаар ажиллах гэх мэтийн талаар хэрэгжүүлэгч газар дээр зөрчил гарсан гэж бодож байвал
- Эрх зүйг зөрчиж нутаг буцаахыг оролдож байгаа бол
- Японы хууль тогтоомж, төрөл бүрийн тогтолцооны талаар хаанаас зөвлөгөө авахаа мэдэхгүй байх үед

Зөвлөх таны эх хэл дээр зөвлөгөө өгөх болно! Утасны төлбөр үнэгүй.

Даваа гараг-Баасан гараг: 11:00-19:00 Бямба гараг, Ням гараг: 9:00-17:00

Вьетнам хэл	Долоо хоног бүр: Даваа-Баасан гараг, Бямба гараг	TEL: 0120-250-168
Хятад хэл	Долоо хоног бүр: Даваа, Лхагва, Баасан гараг	TEL: 0120-250-169
Индонези хэл	Долоо хоног бүр: Мягмар, Пүрэв, Бямба гараг	TEL: 0120-250-192
Филиппин хэл	Долоо хоног бүр: Мягмар, Пүрэв, Бямба гараг	TEL: 0120-250-197
Англи хэл	Долоо хоног бүр: Мягмар, Пүрэв, Бямба гараг	TEL: 0120-250-147
Тайланд хэл	Долоо хоног бүр: Пүрэв, Ням гараг	TEL: 0120-250-198
Камбожи хэл	Долоо хоног бүр: Пүрэв гараг	TEL: 0120-250-366
Мьянмар хэл	Долоо хоног бүр: Мягмар гараг	TEL: 0120-250-302

Дэлгэрэнгүй мэдээллийг 42 хуудас болон Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагын вэбсайтаас (https://www.otit.go.jp) үзнэ үү. Мөн, хамгийн эхний хуудсанд байгаа эх хэл дээр зөвлөгөө өгөх утасны дугаарыг тасархай зураасын дагуу хайчлан авч, түрийвчиндээ хийж хадгална уу.

* Хэрэв таныг зодох, айлган сүрдүүлсэн бол дээрх утасны дугаар руу залгаж, автомат дуудлагын дараа нь “1” товчийг дарна уу. Та тусгай лавлахтай холбогдох болно.

<Эх хэл дээрх зөвлөгөө өгөх сайт>

Гадаад иргэдийн оршин суух ерөнхий мэдээллийн төв

Хилээр орж ирэх ба оршин суух процедурын талаар зөвлөгөө авах бол, доорх заасны дагуу ашиглана уу.

Утас:	0570-013904 03-5796-7112 (IP / PHS /Гадаадаас)
ҮҮйлчилгээ үзүүлэх хэл:	Япон хэл, Англи хэл, Хятад хэл, Солонгос хэл, Испани хэл, Португал хэл, Вьетнам хэл, Непал хэл, Тайланд хэл, Бирм хэл, Сингал хэл
Цахим шуудан:	info-tokyo@i.moj.go.jp
Долоо хоног бүр:	Даваа-Баасан гараг 8:30-17:15

外国人技能実習機構　母国語相談ホットライン

・仕事上や日常生活で悩みや不安を感じたとき
・賃金や時間外労働等について実習先で違反があると感じたとき
・意に反して帰国させられそうなとき
・日本の法律、各種制度に関して相談先が分からないとき　など

相談員がみなさんの母国語で対応します！通話料は無料です。
月曜日～金曜日：11:00～19:00　土曜日・日曜日：9:00～17:00

ベトナム語	毎週：月～金・土	TEL：0120-250-168
中国語	毎週：月・水・金	TEL：0120-250-169
インドネシア語	毎週：火・木・土	TEL：0120-250-192
フィリピン語	毎週：火・木・土	TEL：0120-250-197
英語	毎週：火・木・土	TEL：0120-250-147
タイ語	毎週：木・日	TEL：0120-250-198
カンボジア語	毎週：木	TEL：0120-250-366
ミャンマー語	毎週：火	TEL：0120-250-302

詳しくは43ページ、外国人技能実習機構ＨＰ（https://www.otit.go.jp）を見てください。また最初のページの母国語相談ホットラインの案内を、点線に沿って切り取って、パスケース等に入れておいてください。

※暴行や脅迫などを受けている場合には、上記電話番号にダイヤル後、自動音声アナウンスのあと「１番」をプッシュしてください。専用の窓口に繋がります。

＜母国語相談サイト＞

外国人在留総合インフォメーションセンター

入国在留手続に関する相談は、下記を御利用ください。

電話：　0570-013904
　　03-5796-7112（IP・PHS・海外から）
対応言語：日本語、英語、中国語、韓国語、スペイン語、ポルトガル語、ベトナム語、ネパール語、タイ語、ミャンマー語、シンハラ語
Eメール：info-tokyo@i.moj.go.jp
毎週：　月～金　8:30～ 17:15

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага SNS

Facebook болон X (хуучин Twitter) дээр хэрэгтэй мэдээллийг тогтмол цацдаг. Үүнийг доорх QR кодыг уншуулж харна уу.

Япон хэл

＜Фэйсбүүк＞　＜X (хуучин Twitter)＞

Хялбар япон хэл

＜Фэйсбүүк＞　＜X (хуучин Twitter)＞

外国人技能実習機構 SNS

FacebookとX(旧Twitter)で、役に立つ情報を随時発信しています。以下のQRコードを読み取って御覧ください。

日本語	
＜Facebook＞	＜X（旧Twitter）＞
やさしい日本語	
＜Facebook＞	＜X（旧Twitter）＞

Ур чадварын дадлагын тогтолцоотой холбоотой сурталчилгаа, мэдээллийн видео

Ур чадварын дадлагын тогтолцооны тойм, механизмаас гадна, дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх газруудыг ойлгоход хялбар хэлбэрээр танилцуулж байна. Үүнийг доорх QR кодыг уншуулж харна уу.

Япон хэл
Монгол хэл

技能実習制度に関する広報動画

技能実習制度の概要や仕組みのほか、代表的な支援や相談先などについて、わかりやすく紹介しています。以下のQRコードを読み取って御覧ください。

日本語
モンゴル語

技能実習生手帳（モンゴル語版）

Ур чадварын дадлагажигч нарт зориулсан гарын авлага (Монгол хэл дээрх хувилбар)

所有者（技能実習生氏名）／ Эзэмшигчийн нэр (ур чадварын дадлагажигчийн овог нэр)
氏名／ Овог нэр

監理団体／ Хянагч байгууллага
名称・住所・連絡先／ Байгууллагын нэр, хаяг, холбоо барих хаяг (дэлгэрэнгүй)
《相談員》氏名・連絡先／ “Зөвлөх” Овог нэр, холбоо барих хаяг (дэлгэрэнгүй)

実習実施者／ Хэрэгжүүлэгч газар
名称・住所・連絡先／ Байгууллагын нэр, хаяг, холбоо барих хаяг (дэлгэрэнгүй)
《相談員》氏名・連絡先／ “Зөвлөх” Овог нэр, холбоо барих хаяг (дэлгэрэнгүй)

※この手帳を受け取ったら、できるだけ早く氏名、連絡先等を書きましょう。
* Энэ гарын авлагыг авсан даруйдаа өөийн овог нэр, холбогдох утсаа бичнэ үү.

外国人技能実習機構（OTIT）HP（https://www.otit.go.jp/）
Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (OTIT) вэб хуудас (https://www.otit.go.jp/)

Агуулгын жагсаалт

1. Удиртгал 14
2. Гадаад иргэдийн ур чадварын дадлагын тогтолцоо 14
3. Ур чадварын дадлагын тухай хуулийн талаар 18
4. Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (OTIT) 20
5. Ур чадварын дадлагажигчийн хүлээх үүрэг 22
6. Хилээр орохоос өмнө илгээгч байгууллагад төлөх зардлын тухай 24

(Хянагч байгууллага ба илгээгч байгууллагуудын зохисгүй харилцааны тухай)

7. Ур чадварын дадлагатай холбоотой сэтгэлзүйн бэлтгэл 26
8. Хууль тогтоомжийн хамаарах хүрээ 28
9. Оршин суугчийн үнэмлэх 32
10. Ур чадварын дадлагыг хийхэд бэрхшээлтэй болсон тохиолдолд 34
11. Нутаг буцаах арга хэмжээ авагдах гэж байгаа бол 36
12. Ур чадварын дадлагын хугацаанд гэрлэх, жирэмслэх, төрөх тохиолдолд 36
13. Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагаас үзүүлэх зөвлөгөө (Эх хэл дээр зөвлөгөө өгөх газар) 42
14. Таны зүгээс хийж болох “мэдүүлэг”-ийн тухай 46
    (1) Ур чадварын дадлагын тухай хуульд үндэслэсэн мэдүүлэг 46
    (2) Хөдөлмөрийн стандартын хууль зэрэгт үндэслэсэн мэдүүлэг 48
15. Хөдөлмөрийн холбоотой хууль тогтоомжид хамаарах нь 50
    (1) Хөдөлмөрийн гэрээ 50
    (2) Ажлын цаг болон амралтын цаг, бүх нийтийн амралтын өдөр 52
    (3) Жил бүрийн ээлжийн цалинтай амралт 52
    (4) Цалин 54
16. Нийгмийн даатгал 58
    (1) Нийгмийн даатгалын төрөл ба төлбөр 58
    (2) Нийгмийн даатгалд хамрагдах ажилчид 58
    (3) Нийгмийн даатгалын шимтгэлийн дүн 60
    (4) Нийгмийн халамжийн тэтгэвэр, улсын тэтгэврээс хасалт хийлгэхдээ авах төлбөрийг нэхэмжлэх ажиллагаа 62

目次

1．はじめに 15
2．外国人技能実習制度 15
3．技能実習法について 19
4．外国人技能実習機構（OTIT） 21
5．技能実習生の責務について 23
6．入国前に送出機関等に支払う費用について 25

（監理団体と送出機関の不適切な関係について）

7．技能実習にあたっての心構え 27
8．法令の適用等 29
9．在留カード 33
10. 技能実習を行うことが困難になった場合 35
11. 帰国を強制されそうになった場合 37
12. 技能実習中に結婚・妊娠・出産などをした場合 37
13. 外国人技能実習機構における相談【母国語相談】 43
14. あなたがすることができる「申告」について 47
    （1）技能実習法に基づく申告 47
    （2）労働基準法等に基づく申告 49
15. 労働関係法令に関すること 51
    （1）労働契約 51
    （2）労働時間と休憩・休日 53
    （3）年次有給休暇 53
    （4）賃金 55
16. 社会保険 59
    （1）社会保険の種類と給付 59
    （2）社会保険の対象となる従業員 59
    （3）社会保険料の額 61
    （4）厚生年金、国民年金の脱退一時金の請求手続 63

17. Хөдөлмөрийн даатгал . . . 64
(1) Хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгал . . . 64
(2) Ажил эрхлэлтийн даатгал . . . 64
18. Орлогын албан татвар, оршин суугчийн албан татвар . . . 66
19. Хувийн дугаарын систем ба хувийн дугаарын карт . . . 70
20. Эрүүл мэндийн үзлэг . . . 76
21. Ур чадварын дадлагын явц дахь ослоос сэргийлэх нь . . . 76
22. Япон дахь аж амьдрал . . . 84
23. Төрөл бүрийн лавлагаа, тусламж үзүүлэх цэг . . . 98
i. Хөдөлмөрийн гэрээний талаарх зөвлөгөө (Хот, мужуудын хөдөлмөрийн товчоо болон хөдөлмөрийн стандартын хяналтын алба) . . . 100
ii. Хилийн шалган нэвтрүүлэх ба оршин суух журамтэй холбоотой зөвлөгөө өгөх газар . . 106
iii. Бусад төрлийн лавлах . . . 106
24. Мэдээлэл шинэчлэх судлагаа . . . 110

Ашиглах материал

1. Зөвлөгөө өгөх лавлахын жагсаалт
Хүснэгт 1: Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага . . . 114
Хүснэгт 2: Хөдөлмөрийн ерөнхий зөвлөгөө өгөх булан . . . 116
Хүснэгт 3: Гадаад ажилчдын зөвлөгөө авах булан . . . 120
Хүснэгт 4: Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар . . . 128
Хүснэгт 5: Элчин сайдын яамд болон Консулын газар . . . 130
2. Хөдөлмөрийн гэрээ болон хөдөлмөрийн нөхцлийн бичиг . . . 134
3. Хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгалын нөхөн олговор авах журам . . . 140
4. Ажил эрхлэлтийн даатгал (үндсэн тэтгэмж) авах журам . . . 144
5. Эмнэлгийн байгууллагаас тусламж авахдаа өөрөө мэдүүлэх маягт, үзлэгийн анкет . . . 146
6. Яаралтай үед хэрэглэх Япон хэл . . . 154
7. Япон хэлний сургалтын материал . . . 154
8. Японы газрын зураг . . . 156
9. Нийслэл, хот, мужийн нэр . . . 157

17. 労働保険 . . . 65
（1）労災保険 . . . 65
（2）雇用保険 . . . 65
18. 所得税・住民税 . . . 67
19. マイナンバー制度・マイナンバーカード . . . 71
20. 健康診断 . . . 77
21. 技能実習中の労働災害防止 . . . 77
22. 日本での生活 . . . 85
23. 各種相談・支援窓口 . . . 99
① 労働条件等の相談（都道府県労働局及び労働基準監督署） . . . 101
② 出入国在留手続に関する相談窓口 . . . 107
③ その他各種相談窓口 . . . 107
24. フォローアップ調査 . . . 111

参考資料

1．相談窓口所在一覧
表１：外国人技能実習機構 . . . 115
表２：総合労働相談コーナー . . . 117
表３：外国人労働者相談コーナー . . . 121
表４：出入国在留管理局 . . . 129
表５：各国大使館・領事館 . . . 131
2．雇用契約書及び雇用条件書 . . . 134
3．労災保険給付手続の流れ . . . 141
4．雇用保険（基本手当）受給手続の流れ . . . 145
5．医療機関への自己申告表・補助問診票 . . . 147
6．緊急時に使う日本語 . . . 155
7．日本語学習教材 . . . 155
8．日本地図 . . . 156
9．都道府県名 . . . 157

1. Удиртгал

Энэхүү ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага нь та бүхэнд Японд эрүүл энх, үр бүтээлтэй ур чадварын дадлага хийхэд туслах зорилгоор хэрэгтэй мэдээллийг багцаар хүргэж байна.

Ур чадварын дадлагажигч болсноор Япон улсын хөдөлмөрийн гэрээн дор төрөл бүрийн ур чадвар, технологи болон мэдлэгийг (цаашид ур чадварууд гэнэ) олж авах болно. Энэ хугацаанд Япон улсын олон төрлийн хууль үйлчлэх тул тус гарын авлагад холбогдох хуулиудын дундаас нэн чухалд тооцогдох хуулийг дурьдав. Түүнчлэн Японд аж төрөхөд зайлшгүй мэдэх ёстой зүйлийг мөн багтаасан болно.

Энэхүү гарын авлагыг бүрэн дүүрэн ашиглаж цаашдын Япон дахь амьдралаа үр бүтээлтэй утга учиртай өнгөрүүлнэ гэдэгт итгэж байна.



2. Гадаад иргэдийн ур чадварын дадлагын тогтолцоо

“Гадаад иргэдийн ур чадварын дадлагын тогтолцоо” нь гадны ажилчид Японы аж үйлдвэр зэрэг салбарт ур чадвар эзэмших, нутаг буцсаны дараа өөрийн эзэмшсэн ур чадвараа ашиглан өөрийн улсын аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд хувь нэмэр оруулах зорилготой юм.

Юуны өмнө ур чадварын дадлагыг хэрэгжүүлэгч газрын боловсруулсан ур чадварын төлөвлөгөөн дээр үндэслэн удирдан явуулна. Тэрхүү төлөвлөгөөний дагуу өөрийн ур чадвараа сайжруулахын тулд өдөр бүр юу хийвэл зохих талаар маш сайн бодсоны үндсэн дээр ур чадварын дадлагаа хэрэгжүүлцгээе.



Ур чадварын дадлагын явц

(Ур чадварын 1-р зэргийн дадлага)
- Японд ирсэний дараа тэнхимийн сургалтанд хамрагдана.
- Японд хэрхэн аж төрөх болон ур чадварын дадлагын тогтолцооны талаар илүү ихийг мэдэж авцгаая.
- Үүний дараа дадлага хэрэгжүүлэгч газрын дор дадлага ажил эхлэнэ.

*** Зорилго: Ур чадварын түвшин тогтоох анхан шатны шалгалт (практик ур чадвар болон онолын шалгалтанд) тэнцэх**

(Ур чадварын 2-р зэргийн дадлага)
- Ур чадварын 1-р зэргийн дадлагаар олж авсан ур чадваруудыг илүү сайжруулахыг зорилгоо болгоё.

*** Зорилго: Ур чадварын түвшин тогтоох 3-р түвшиний шалгалт (практик ур чадварын шалгалтанд) тэнцэх**

3-р зэргийн дадлагын ажилд дэвшин шилжихээс өмнө, эсвэл ур чадварын 3-р зэргийн дадлага эхэлснээс хойш 1 жилийн дотор 1 сараас дээш хугацаатайгаар нутаг буцах шаардлагатай.

(Ур чадварын 3-р зэргийн дадлага)
- Ур чадварын 2-р зэргийн дадлагаар олж авсан ур чадваруудыг бодитоор хэрэглэх үе шат болно.
- Ур чадвараа улам сайжруулъя.

*** Зорилго: Ур чадварын 2-р түвшний шалгалт (Практик шалгалт)-нд тэнцэх**

(Нутаг буцсаны дараа)
Мэдээлэл шинэчлэх судлагаанд хувь нэмрээ оруулцгаая!
Нутаг буцсаны дараа оршин байгаа улсын хаягаар санал асуулгын хуудас очих ба нутаг буцсаны дараах хөдөлмөр эрхлэлтийн байдал ба Японд эзэмшсэн техникийн ур чадвараа хэрхэн ашиглаж байгаа талаар мэдэгдэнэ үү. (Дэлгэрэнгүйг 110-р хуудаснаас)

1. はじめに

この技能実習生手帳は、技能実習生のみなさんが、日本において、健康で充実した技能実習生活を過ごすことができるように、あなたの役に立つ情報をまとめたものです。

技能実習生になったあなたは、日本国内で雇用契約のもとで様々な技能、技術又は知識（以下「技能等」という。）を身につけることとなります。この間あなたには、多くの日本の法律がかかわってきます。この手帳には、そういったあなたに関係する法律の中で、特に大切と思われるものや、日本で生活するに当たって、知っておかなくてはならないことが記載されています。

この手帳を十分に活用して、これからの日本での生活があなたにとって有意義ですばらしいものとなることを祈っています。



2. 外国人技能実習制度

「外国人技能実習制度」は、諸外国の労働者に日本の産業等に関する技能等を修得してもらい、帰国後に修得した技能等を生かして、自国の産業の発展のために活躍してもらうことを目的としているものです。

あなたの技能実習は、あらかじめ実習実施者で作成された技能実習計画に基づいて実施されます。あなたは、その計画に従って目標とする技能等を身につけるために、毎日何をすればいいか、しっかり考えながら技能実習に取り組みましょう。



技能実習の流れ

（技能実習1号）
・入国後に座学による講習があります。
・日本での生活や技能実習制度についてしっかり身につけましょう。
・その後、実習実施者の元で実習が始まります。
※目標：技能検定基礎級（実技・学科試験）合格

（技能実習2号）
・技能実習1号で修得した技能等の向上を目指しましょう。
※目標：技能検定3級（実技試験）合格

3号に移行する前、又は、技能実習３号を開始してから１年以内に1か月以上帰国する必要があります

（技能実習3号）
・技能実習2号で修得した技能等の応用段階となります。
・さらに技術をみがきましょう。
※目標：技能検定２級（実技試験）合格

（帰国後）
フォローアップ調査に協力してください！
帰国後にあなたのところにアンケート調査票が送られてきますので、帰国後の就職状況や日本で修得した技能等の活用状況を教えてください。（詳細は111ページ）

* Зорилго

(Ур чадварын дадлага хийх явцад өгөх ёстой шалгалтын төрөл)

Ур чадварын дадлага	Өгөх ёстой шалгалт	Шаардагдах техникийн ур чадвар зэргийн түвшин
1-р зэрэг	Ур чадварын түвшин тогтоох анхан шатны шалгалт (ур чадварын дадлагын үнэлгээний анхан шатны зэргийн шалгалт)	Хамгийн үндсэн шатны ажлыг хийхэд шаардлагатай суурь техникийн ур чадвар гэх мэт
2-р зэрэг	Ур чадварын түвшин тогтоох 3-р түвшиний шалгалт (ур чадварын дадлагын үнэлгээний мэргэжлийн зэргийн шалгалт)	Анхан шатны ур чадварын дадлагажигчийн эзэмшвэл зохих ердийн техникийн ур чадвар гэх мэт
3-р зэрэг	Ур чадварын түвшин тогтоох 2-р түвшиний шалгалт (ур чадварын дадлагын үнэлгээний дээд түвшиний шалгалт)	Дунд шатны ур чадварын дадлагажигчийн эзэмшвэл зохих ердийн техникийн ур чадвар гэх мэт

Та ур чадварын 2 эсвэл 3-р зэрэгтэй болохын тулд өмнөх шатны шалгалтанд тэнцэхгүй бол болохгүй. Шалгалтанд эхний удаа тэнцэхгүй бол дахин өгөх боломжтой ба зорилгодоо хүрэхийн төлөө өдөр бүр ур чадварын дадлагаа хийцгээе.

(1) Ур чадварын дадлагын эхний жил “Ур чадварын 1-р зэргийн дадлага”

Юуны өмнө ур чадварын 1-р зэргийн дадлага хийхэд Япон улсад ирсэний дараа сургалтанд хамрагдана. Сургалтаар Япон улсад ур чадварын дадлага хийхэд шаардлагатай мэдлэг олгоно. *Сургалтын дэлгэрэнгүй агуулга*:

- Япон хэл
- Япон улсад аж төрөхөд шаардагдах энгийн мэдлэг
- Ур чадварын дадлага хийхэд шаардагдах хуулийн мэдлэг
- Ур чадвар эзэмшихэд шаардагдах мэдлэг

Үүний дараа дадлага хэрэгжүүлэгч газрын хамт хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ур чадваруудыг эзэмшинэ.

Ур чадварын 2-р зэргийн дадлага хийх төлөвлөгөөтэй бол ур чадварын түвшин тогтоох шалгалтын (ур чадварын дадлагын үнэлгээний шалгалт) практик шалгалт болон онолын шалгалтанд тэнцэх ёстой. Тийм учраас суурь зэрэг (анхан шатны) авах шалгалтанд тэнцэхийг зорилгоо болгох шаардлагатай.

(2) Ур чадварын дадлагын 2 ба 3 дахь жил “Ур чадварын 2-р зэргийн дадлага”

Ур чадварын 2-р зэргийн хувьд ур чадварын 1-р зэргийн дадлагаар олж авсан ур чадваруудыг илүү сайн эзэмших (өөрийн болгох) үүднээс зарчмын хувьд анхны хэрэгжүүлэгч газар дээр үргэлжлүүлэн дадлага хийж, эзэмшинэ.

Ур чадварын 2-р зэргийн дадлага дуусах үед, ур чадварын түвшин тогтоох шалгалт (ур чадварын дадлагын үнэлгээний шалгалт) өгөх хэрэгтэй ба 3-р зэрэг (мэргэжлийн зэрэг) авах шалгалтад тэнцэх зорилго тавих ёстой.

(3) Ур чадварын дадлагын 4 ба 5 дахь жил “Ур чадварын 3-р зэргийн дадлага”

Ур чадварын 3-р зэргийн хувьд ур чадварын 2-р зэргээр олж авсан ур чадваруудыг улам сайжруулах үе шат болох учир хамгийн сайн хяналтын байгууллага болон дадлага хэрэгжүүлэгч газрын дор ур чадварын дадлага хийх болно.

Ур чадварын 1-р зэргээс ур чадварын 2-р зэрэг хүрэхэд зарчмын хувьд анхны хэрэгжүүлэгч газар дээр үргэлжлүүлэх ёстой хэдий ч, ур чадварын 3-р зэргийн дадлага хийхэд 2-р зэрэг хүртэл авсан хэрэгжүүлэгчээр үл хязгаарлагдан дадлагажигч өөрөө хэрэгжүүлэгч газраа сонгох боломжтой болно.

Түүнчлэн ур чадварын 3-р зэргийн дадлагын ажилд дэвшин шилжиж ажиллахын тулд, ур чадварын 3-р зэргийн дадлага эхлэхээс өмнө, эсвэл ур чадварын 3-р зэргийн дадлага эхэлснээс хойш 1 жилийн дотор заавал 1 сараас дээш хугацаатайгаар нутагтаа буцна. Ур чадварын 3-р зэргийн дадлагын ажилд дэвшин шилжиж ажиллах болсон тохиолдолд хамгийн дээд тал нь 5 жилийн турш эх нутгаасаа хол байх учраас гэр бүл болон ах дүү нартайгаа холбоотой байгаарай.

Ур чадварын 3-р зэргийн дадлага дуусах үед, ур чадварын түвшин тогтоох (ур чадварын дадлагын үнэлгээний шалгалт) шалгалт өгөх ёстой ба 2-р зэрэг (дээд түвшин) авах шалгалтад тэнцэх зорилго тавих ёстой.

Ур чадварын 3-р зэргийн дадлагатай холбогдуулан хэрэгжүүлэгч газрыг өөрчлөхөөр бол хянагч байгууллагатай хамтран дараагийн ажил олгох арга хэмжээ авах бөгөөд лавлах зүйл гарвал, Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (доор Байгууллага гэх)-д хандах эсвэл эх хэл дээр зөвлөгөө авч санал бодлоо чөлөөтэй солилцоорой(42 х у у д с ы г ү з н э үү).

(4) “Тусгай ур чадвар 1-р зэрэг” рүү шилжих

Ур чадварын 2-р зэргийн дадлагыг сайн хийж дуусгасан дадлагажигч тусгай ур чадвар 1-р зэрэг рүү шилжихдээ ур чадварын шалгалт ба Япон хэлний түвшин тогтоох шалгалтаас чөлөөлөгдөнө.

Тусгай ур чадварын 1-р зэрэг гэдэг нь Японд ажиллах эрхтэй оршин суух зөвшөөрлийн нэг юм.

※目標 （各技能実習の段階で目標にする検定試験の種類です。）

技能実習	目標とする検定試験	要求される技能等の水準
1号	技能検定基礎級 （又は技能実習評価試験初級）	基本的な業務を遂行するために必要な基礎的な技能等
2号	技能検定3級 （又は技能実習評価試験専門級）	初級の技能労働者が通常有すべき技能等
3号	技能検定2級 （又は技能実習評価試験上級）	中級の技能労働者が通常有すべき技能等

あなたが技能実習2号又は技能実習3号を行うためには、前段階の到達目標としてあらかじめ定めた検定試験に合格しなければなりません。試験に一度失敗しても、もう一度チャンスがあるので目標に向かって、日々、技能実習に取り組みましょう。

(1) 技能実習1年目 「技能実習1号」

技技能実習１号においては、まず、入国後の講習があります。講習では日本で技能実習を行うために必要な知識を学びます。具体的な講習の内容は、以下のとおりです。

具体的な講習の内容は、以下のとおりです。

・日本語
・日本での生活一般に関する知識
・技能実習を行う上で必要な法律の知識
・技能を修得する上で必要な知識

その後、実習実施者との雇用契約の下で技能等の修得を行います。

技能実習2号に移行する予定がある場合は、技能検定（又は技能実習評価試験）の実技試験と学科試験の受検が必須で、基礎級（又は初級）への合格を目標としなければなりません。

(2) 技能実習2年目、3年目 「技能実習2号」

技能実習2号においては、技能実習1号で修得した技能等をさらに習熟する（身につける）ために、原則として同じ実習実施者において、引き続き技能等を修得します。

技能実習2号の修了時には、技能検定（又は技能実習評価試験）の実技試験の受検が必須で、3級（又は専門級）の実技試験への合格を目標としなければなりません。

(3) 技能実習4年目、5年目 「技能実習3号」

技能実習3号は、技能実習2号で身につけた技能等に熟達するための段階となり、優良な監理団体及び実習実施者のもとで技能実習を行うことになります。

技能実習1号から技能実習2号に移行する場合は、原則として同じ実習実施者のもとで技能実習を継続しなければなりませんが、技能実習3号に移行する場合は、技能実習2号までの実習実施者に限定されず、技能実習生自身が実習実施者を選ぶことが可能となります。

また、技能実習3号に移行する場合は、技能実習３号開始前、又は、技能実習３号開始後１年以内に必ず１か月以上帰国しなければなりません。技能実習3号に移行した際は、最長5年間母国から離れることになりますので、家族と会うなど母国とのつながりを再確認してください。

技能実習3号の修了時には、技能検定（又は技能実習評価試験）の実技試験の受検が必須で、2級（又は上級）への合格を目標としなれければなりません。

技能実習３号において実習実施者を変更する場合は、監理団体に求職の手続を行うこととなりますが、分からないことがあれば、外国人技能実習機構（以下「機構」という。）又は母国語相談（43ページ参照） に気軽に相談してください。また、機構のホームページでも案内していますので併せてチェックしてください。

(4)「特定技能1号」への移行

技能実習2号を良好に修了した技能実習生は、特定技能1号への移行にあたって、技能試験や日本語能力試験が免除されます。特定技能1号とは日本で働くための在留資格の1つです。

3. Ур чадварын дадлагын тухай хуулийн талаар

Энэхүү хуулийн албан ёсны нэр нь “Гадаадын ур чадварын дадлагажигч нарын зүй зохистой дадлагын хэрэгжилт ба ур чадварын дадлагажигч нарын хамгаллын талаарх хууль” (цаашид “ур чадварын дадлагын тухай хууль” гэнэ). Тус хуулийг 2016 оны 11-р сарын 28-ны өдөр соёрхон батлсан ба 2017 оны 11-р сарын 1-с эхлэн хэрэгжиж эхлэнэ.

Ур чадварын дадлагыг зүй зохистойгоор хийх, ур чадварын дадлагажигч нарыг хамгаалах үүднээс (1) ур чадварын дадлага хэрэгжүүлэгч газар болон хэрэгжилтийг хянах хянагч байгууллагад зориулан шаардлагатай зохицуулалтыг хийж, захирах болон хяналтын тогтолцоог бэхжүүлэхийн хамт (2) ур чадварын дадлагажигч нарын хамгаллын төлөөх арга хэмжээг хуулиар тогтоож өгсөн болно. Үүнээс гадна хамгийн сайн хэрэгжүүлэгч газар болон хяналтын байгууллага дээр илүү өндөр зэргийн ур чадварын дадлага хэрэгжүүлэх боломжтой болсон.



Ур чадварын дадлагын тухай хуулийн агуулга (тайлбар)

- Ур чадварын дадлагын тогтолцооны зүй зохистой байдал болон ур чадварын дадлагажигч нарын хамгаллын тухай
  - Ур чадварын дадлагын баримтлах үндсэн зарчим болон холбогдох хүмүүсийн үүрэг хариуцлагыг тогтоохын зэрэгцээ ур чадварын дадлагатай холбоотой үндсэн чиглэлийг боловсруулсан байх.
  - Ур чадварын дадлагажигч тус бүрээр гаргасан ур чадварын төлөвлөгөө нь магадлан итгэмжлэх тогтолцоон дээр суурилах тул итгэмжлэлийн стандарт, магадлан итгэмжлэх зайлшгүй шалтгааныг тогтоохоос гадна, холбогдох сайдын тайланг авах, сайжруулахын төлөөх тушаал, итгэмжлэлийг хүчингүй болгох зэрэг эрх мэдлийг тодорхойлно.
  - Хянагч байгууллагын хувьд зөвшөөрөл авсан байх шаардлагатай ба зөвшөөрлийн стандарт болон зайлшгүй байх шалтгааныг тогтоохоос гадна, дагаж баримтлах зүйлс, холбогдох сайдын тайлан авах, сайжруулахын төлөөх тушаал, зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг эрх мэдлийг тодорхойлно.
  - Ур чадварын дадлагажигч нарын хамгаалалтай холбогдуулан тэдгээрийн эрх зөрчигдөх явдлыг хориглох дүрмийг тогтоон, дүрэм зөрчсөн тохиолдолд шийтгэл оноох ба ур чадварын дадлагажигч нарын санал асуултад хариулах, мэдээлэл түгээх, тусламж зэрэг үзүүлнэ.
- Ур чадварын дадлагажигчийн тухай тогтолцооны нэмэлт өргөтгөл
  - Зөвхөн хамгийн сайн хэрэгжүүлэгч болон хяналтын байгууллага нь 3-р зэргийн (4 дэх болон 5 дахь жилдээ ур чадварын дадлага хийх) ур чадварын дадлага хийх дадлагажигч нарыг хүлээн авах боломжтой.

Онцгойлон ур чадварын дадлагажигч нарын хамгаллын асуудал нь дараах байдлаар хуулиар тогтоогдсон байна:

- Ур чадварын дадлагажигч нарын эрх зөрчигдөх явдлыг хориглох дүрэм журмыг тогтоон, дүрэм зөрчсөн тохиолдолд шийтгэл ноогдуулна.

Ур чадварын дадлагажигч нарын эрх зөрчигдөх үйлдлүүд (тайлбар)

i. Ур чадварын дадлагыг хүчээр хийлгэх
ii. Торгууль ноогдуулах арга хэмжээ авах
iii. Хадгаламжийн мөнгийг хянах гэрээ байгуулах
iv. Аялалын тасалбар болон оршин суух үнэмлэх хадгалах
v. Хувийн амьдралын эрх чөлөөг бууруугаар хязгаарлах зэрэг үйлдлүүд орно

- Хэрэгжүүлэгч газар болон хянагч байгууллага ур чадварын дадлагын хуулийг зөрчсөн нь үнэн бол ур чадварын дадлагажигч Хилийн шалган нэвтрүүлэх , оршин суух хяналтын газрын дарга болон Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдад мэдээлж болохыг ил тод заасан.
  Түүнчлэн мэдээлснээс үүдэлтэй гадуурхах явдалд шийтгэл ноогдуулахаар тогтоосон.
- Байгууллага нь ур чадварын дадлагажигч нартай санал бодол солилцохоос гадна мэдээллээр ханган дэмжлэг үзүүлнэ.

3. 技能実習法について

この法律の正式な名称は「外国人の技能実習の適正な実施及び技能実習生の保護に関する法律」（以下「技能実習法」という。）＜公布：平成28年（2016年）11月28日、施行：平成29年（2017年）11月１日＞といいます。

この法律は、技能実習の適正な実施及び技能実習生の保護を図るため、①技能実習を実施する実習実施者やその実施を監理する監理団体に対して必要な規制を設け、管理監督体制を強化するとともに、②技能実習生の保護を図る措置などを定めています。併せて、優良な実習実施者や監理団体については、より高度な技能実習の実施を可能にしました。



【解説】技能実習法の概要

○技能実習制度の適正化・技能実習生の保護
- 技能実習の基本理念及び関係者の責務を定めるとともに、技能実習に関し基本方針を策定すべきこと。
- 技能実習生ごとに作成する技能実習計画について、認定制とし、認定の基準や認定の欠格事由等を定めるほか、主務大臣の報告徴収、改善命令、認定の取消し等の権限を規定すること。
- 監理団体について、許可制とし、許可の基準や許可の欠格事由を定めるほか、遵守事項、主務大臣の報告徴収、改善命令、許可の取消し等の権限を規定すること。
- 技能実習生の保護に関する措置として、技能実習生に対する人権侵害行為等について、禁止規定を設け、違反に対する罰則を規定するとともに、技能実習生に対する相談対応や情報提供、援助等を行わせること。

○技能実習制度の拡充
- 優良な実習実施者・監理団体に限定して、第3号技能実習生の受入れ（4年目及び5年目の技能実習の実施）を可能とすること。

特に技能実習生の保護に関しては以下の通り定めています。
- 技能実習生に関する人権侵害行為等について禁止規定を設け、罰則を規定。


【解説】技能実習生に対する人権侵害行為

①技能実習を強制する行為
②違約金等を定める行為
③貯蓄金を管理する契約を締結する行為
④旅券・在留カードを保管する行為
⑤私生活の自由を不当に制限する行為

- 実習実施者や監理団体に技能実習法違反の事実がある場合、技能実習生は出入国在留管理庁長官及び厚生労働大臣に申告できることを明記。
  また、申告を理由とする不利益取扱いに対する罰則も規定。
- 機構において技能実習生に対する相談対応や情報提供、援助等を実施。

4. Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (OTIT)

Тус байгууллага нь ур чадварын дадлагын тухай хуульд үндэслэгдэн байгуулагдсан Хууль зүйн Яам болон Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яаманд харъяалагдах зөвшөөрөл бүхий хуулийн этгээд юм. Уг байгууллага нь дараах эрх, үүргийг биелүүлнэ:



А: Байгууллагын зүгээс хяналтын байгууллагад эдлэх эрх мэдэл
- i. Хянагч байгууллагад гүйцэтгэлийн судлагаа явуулна
  Тогтмол хугацааны гүйцэтгэлийн судлагаа/ мэдүүлэгт үндэслэсэн гүйцэтгэлийн судлагаа
- ii. Хянагч байгууллагаас тайлан шаардана


Б: Байгууллагын зүгээс дадлага хэрэгжүүлэгч газарт эдлэх эрх мэдэл
- i. Ур чадварын төлөвлөгөөний магадлан итгэмжлэл
- ii. Дадлага хэрэгжүүлэгчдэд хэрэгжилтийн судлагаа явуулна
  Тогтмол хугацааны хэрэгжилтийн судлагаа/ мэдүүлэгт үндэслэсэн хэрэгжилтийн судлагаа
- iii. Дадлага хэрэгжүүлэгчээс тайлан шаардана
- iv. Дадлага хэрэгжүүлэгчийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авна

В: Байгууллагын зүгээс ур чадварын дадлагажигч нарт хүлээх үүрэг
- i. Эх хэл дээрх зөвлөгөө, мэдүүлэгт хариу өгөх
  - Утсаар зөвлөгөө өгөх (дэлгэрэнгүйг 42-р хуудаснаас үзнэ үү)
  - Цахим шуудангаар зөвлөгөө өгөх (24 цагийн турш нээлттэй)
    - Байгууллагын вэб сайтан дахь эх хэлээр зөвлөгөө өгөх хуудаснаас цахим шуудан хэлбэрээр хариу өгнө
  - Онлайн дуудлага (Zoom)-р зөвлөгөө авах
- ii. Төв байгууллага, орон нутаг дахь оффис, салбаруудаар дамжуулан зөвлөгөө өгч мэдүүлэг авна (Төв байгууллага, орон нутгийн оффис болон салбаруудын хаягийг 114-р хуудаснаас үзнэ үү)
- iii. Дадлага хэрэгжүүлэгч газрыг солиход дэмжлэг үзүүлэх
  - Дараах тохиолдолд дэмжлэг үзүүлнэ:
    - Ур чадварын дадлага гүйцэтгэхэд бэрхшээлтэй болсон хэдий ч таны зүгээс ур чадварын дадлага гүйцэтгэхийг хүсч байвал (Дэлгэрэнгүйг 34-р хуудаснаас)
  - Хэрэгжүүлэгч газрыг өөрчлөх болсонтой холбогдуулан эх хэл дээрх зөвлөгөө эсвэл байгууллагын төв, орон нутаг дахь оффис, салбарт хандан зөвлөгөө авна уу. Түүнчлэн дараах сайтыг хэрэглэнэ үү.

Байгууллагын вэб сайтад байрлах дадлага хэрэгжүүлэгч газрыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх сайт:
https://www.support.otit.go.jp/jisshu/jp/

4 . 外国人技能実習機構（OTIT）

機構は、技能実習法に基づいて設立された法務省と厚生労働省が所管する認可法人です。
機構は以下の権限・役割を果たします。



A：機構の監理団体に対する権限
①監理団体に対して実地検査を実施
定期的な実地検査／申告に基づく実地検査
②監理団体から報告を求める

B：機構の実習実施者に対する権限
①技能実習計画の認定
②実習実施者に対して実地検査を実施
定期的な実地検査／申告に基づく実地検査
③実習実施者から報告を求める
④実習実施者の届出の受理

C：機構の技能実習生に対する役割
①母国語による相談・申告への対応
○電話相談（詳細は43ページ）
○電子メールによる相談（24時間受付対応）
・機構ホームページ内母国語相談サイトからメールフォームにより対応。
○オンライン通話（Zoom）による相談
②本部、地方事務所・支所における相談・申告
（本部、地方事務所・支所の住所連絡先は115ページ）
③実習先の変更支援
○以下のような場合に支援を行います。
・技能実習を行うことが困難になった場合で、あなたが引き続き技能実習を希望しているとき。（詳細は35ページ）
○実習先の変更については、母国語相談又は機構本部、地方事務所・支所に相談してください。また、以下のサイトもご活用ください。

【機構ホームページ内実習先変更支援サイト】
https://www.support.otit.go.jp/jisshu/jp/

5. Ур чадварын дадлагажигчийн хүлээх үүрэг

Ур чадварын дадлагажигч нь ур чадварын дадлагад сурахад шамдах ба сурсан ур чадвараа тухайн улсад гарган ажиллах үүрэгтэй.
(Ур чадварын дадлагын тухай хуулийн 6-р зүйл)

Дээрх байдлаар Ур чадварын дадлагын тухай хуулийн 6-р зүйлд ур чадварын дадлагажигчийн хүлээх үүрэг тогтоогдсон байх ба үүнээс харахад ур чадварын дадлагажигч нар ур чадварын дадлагад шамдах ёстой.

Ур чадварын дадлагажигч та бүхэн ур чадварын дадлагын тухай хуульд заасан ур чадварын дадлагажигчийн хүлээх үүргийн дагуу, дадлагажих газартаа ур чадварыг эзэмшиж, эх орондоо очоод эзэмшсэн ур чадвараа ашиглан ажиллаарай.

Тиймээс ур чадварын дадлагажигч та бүхэн, жишээ нь ур чадварын дадлага хэрэгжүүлэгч нэг ижил газар байсан ч тус газарт ур чадварын дадлагажигчийн статусаар өөр төрлийн ажил хөдөлмөр эрхлэх, болон өөр бусад газарт цагийн ажил хийхийг хүлээн зөвшөөрдөггүй.

Эдгээр үйлдлийг хийвэл, та Япон улсын хуулиар шийтгэл хүлээх тохиолдол гарах учир маш сайн анхаарна уу.



“Ур чадварын дадлагажигч ажлын байраа орхиж алга болох асуудал”

Сүүлийн жилүүдэд, ур чадварын дадлагажигчаар Япон улсад ирсэн боловч, дадлагажих хугацаандаа ажлын байраа орхин алга болох үзэгдэл нэмэгдэж байгаа нь томоохон асуудал үүсгэж байна.

Дадлага хэрэгжүүлэгч газраасаа алга болж өөр газар ажил хөдөлмөр эрхлэх нь Хилийн шалган нэвтрүүлэх тухай хуулиар олгогдсон статусыг зөрчсөнд тооцогдож, улсын хилээр албадан гаргах хүртэлх хариуцлага хүлээлгэхээс гадна гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял шийтгэл ногдуулах тул, энэхүү үйлдэл нь та бүхэнд маш муугаар нөлөөлнө. Тиймээс, найз нөхөд болон SNS-р “Наад газраа орхиод ирвэл, өндөр цалинтай ажил байна.” гэх мэтийн ярианд итгэхгүй, хуурташгүй байхыг анхаарууллья.

Ажлын байраа орхин алга болох нь таныг хууль зөрчигч болгоод зогсохгүй, аль ч талдаа ашигтүй зүйл учраас, ажлын байраа орхиж, өөр газарт ажил хөдөлмөр эрхлэх саналыг хүлээж авахгүй байхыг хатуу анхаарууулж байна.

Хянагч байгууллага болон дадлага хэрэгжүүлэгч нар хүний эрхийг зөрчсөн тохиолдолд эх хэлээрээ зөвлөгөө авах, мөн манай байгууллагад дадлага хийх газрыг өөрчлүүлэх туслалцаа авах боломжтой. Эргэлзэлгүй бидэнтэй холбоо барина уу. (42 хуудсыг үзнэ үү).





“Хилийн тухай хуулийн торгууль, шийтгэл гэх мэт”

Хууль бусаар оргосон бол: 3 хүртэлх жилийн хугацаагаар хорих ял эсвэл 3 сая иен хүртэлх торгууль ногдуулна.

Статусын ангилалаас гадуурх үйл ажиллагаа эрхэлсэн бол: 1-ээс доош жилээр хорих ял эсвэл 2 сая иенээс доош торгууль ногдуулна.

(Санаатайгаар хийсэн нь тодорхой байх тохиолдолд, 3 аас доош жилээр хорих ял эсвэл 3 сая иенээс доош торгууль ногдуулна.)

Хууль бусаар ажил хөдөлмөр эрхлэхийг зөвлөсөн бол: 3-с доош жилээр хорих ял эсвэл 3 сая иенээс доош торгууль ногдуулна.

５．技能実習生の責務について

技能実習生は、技能実習に専念することにより、技能等の修得等をし、本国への技能等の移転に努めなければならない。
（技能実習法第6条）

技能実習法第6条には技能実習生の責務が規定されており、この責務からも明らかなように、技能実習生は技能実習に専念することとされています。

技能実習生の皆さんは、この技能実習法の理念に基づき実習先で技能を修得し、本国で修得した技能を役立ててください。

また、技能実習生の皆さんは、在留資格「技能実習」で本邦に入国しており、技能実習以外の、他の仕事をすることはできません。実習先以外の他所で、仕事をすることもできません。

したがって、たとえ同じ実習先であっても技能実習以外の仕事として、アルバイトをすることは認められていません。

これらの行為は、あなた自身も日本の法令により処罰を受ける場合もありますので、注意してください。

≪技能実習生の失踪問題≫

近年、技能実習生として来日したにもかかわらず、技能実習の途中で実習先から失踪する者が増加しており、大きな問題となっています。

実習先から失踪して別の仕事をすることは、入管法の資格外活動違反として退去強制の対象となりうるほか、犯罪として処罰されることのある行為であり、みなさんにとって何ら利益になりません。ですから、友人やＳＮＳなどを通じて「実習先から失踪すれば、もっとお金が稼げる仕事がある。」などの誘いがあったとしても決してこのような誘いに乗ってはいけません。

監理団体や実習実施者から人権侵害行為を受けている場合などは、母国語で相談を受け付けることや、機構が実習先の変更を支援することもできます。ためらわずに、機構に相談してください(43ページ参照)。







≪入管法の罰則等≫

不法残留罪：3年以下の拘禁刑若しくは300万円以下の罰金

資格外活動の罪：1年以下の懲役若しくは200万円以下の罰金
（専ら行っていると明らかに認められる場合は、3年以下の懲役若しくは300万円以下の罰金）


不法就労助長罪：3年以下の拘禁刑若しくは300万円以下の罰金

6. Хилээр орохоос өмнө илгээгч байгууллагад төлөх зардлын тухай (Хянагч байгууллага ба илгээгч байгууллагуудын зохисгүй харилцааны тухай)

Ур чадварын дадлагажигч та бүхний Япон улсын хилээр орохоос өмнө төлөх зардлын талаар, манай байгууллагад илгээх бичиг баримтанд, “гадаадын илгээгч байгууллагаас шаардах зардлын задаргаа (2-10 тоот ашиглах маягт)” (доор “зардлын задаргаа” гэх) -ны тухай бичиж, шаардагдах зардлын агуулгыг ур чадварын дадлагажигч хүнд ойлгомжтойгоор тайлбарлах үүргийг илгээгч байгууллага хүлээнэ. Түүнчлэн ур чадварын дадлагажигч Японд ирэхээс өмнө "Ур чадварын дадлагажигчаар явахаар эх орондоо төлсөн зардлын дэлгэрэнгүй задаргаа (1-21 тоот ашиглах маягт)" гэсэн бичиг баримтад гарын үсэг зурах шаардлагатай. Энэ бол ур чадварын дадлагажигч та бүхэн илгээгч байгууллагад төлсөн зардлын талаар хангалттай тайлбар авч, түүнд бичигдсэнээс өөр төлбөр зардал төлөөгүй гэдгийг баталгаажуулах зорилготой зүйл юм. Таны төлсөн төлбөрийн дүн бичиг баримтанд бичигдсэнтэй таарч байгаа эсэхийг тулгаж шалгасны дараа гарын үсгээ зурна уу. Мөн та төлбөрийн баримтаа илгээгч байгууллагаас гаргуулан авч, хадгална уу. Хожим нь тэрхүү төлбөрийн баримт нь шударга бусаар төлбөр хураамж авсан гэх мэтийг нотлох баримт болж болзошгүй юм. Түүнчлэн, илгээгч байгууллага ур чадварын дадлагажигч болон түүнтэй холбогдох хүн (гэр бүл)-с ажлын байраа орхин алга болохоос урьдчилан сэргийлэх үүднээс барьцааны мөнгө авах, гэрээний гүйцэтгэлийн торгууль тогтоох, хүчирхийлэх зэргээр хүний эрх зөрчсөн гэх мэт үйлдэл хийхийг хориглодог. Эдгээрх зохисгүй үйлдэлд өртсөн тохиолдолд, шууд манай байгууллагад хандаж мэдэгдэнэ үү. (114-р хуудаснаас үзнэ үү).

Түүнчлэн, ур чадварын дадлагын хуулийн 28-р зүйлийн 1-р заалтанд, хянагч байгууллага хяналтын үйл ажиллагаатай холбогдуулан, хяналтын групп хэлбэртэй дадлага хэрэгжүүлэгч, хяналтын групп хэлбэртэй ур чадварын дадлагажигч болон бусад холбогдох хүнээс ямар ч нэрээр, хураамж ба шан харамж авч болохгүйг заасан байдаг. (Гэвч, тус зүйлийн 2-р заалтанд хяналтын үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай гэж үзэх зардлын тухайд, түүнийг ашиглах зорилго, мөнгөн хэмжээг урьдчилан тодорхойлсны үндсэн дээр хураамж авч болно гэж заасан байдаг. Үүнийг “хяналтын зардал” гэнэ.). Хянагч байгууллага хяналтын зардалд ороогүй мөнгийг илгээгч байгууллага болон ур чадварын дадлагажигчтай холбогдох хүнээс нэхэмжилсэн тохиолдолд (жишээ нь, хянагч байгууллага илгээгч байгууллага зэргээс буцааж авсан тохиолдолд), Хяналтын байгууллага нь хянан шалгагчийн байгууллагын зөвшөөрлийг цуцлах шийтгэл хүлээлгэх тул, хэрэв ийм зүйл гарч байгааг мэдвэл, манай байгууллагад хандана уу.

Түүнчлэн, эдгээр үйлдлийн талаар мэдэгдэж зөвлөгөө авснаар, ур чадварын дадлагажигч та бүхний эрх ашигт халдахгүй.




６．入国前に送出機関等に支払う費用について（監理団体と送出機関の不適切な関係について）

技能実習生の皆さんが、日本に入国する前に支払う費用については、機構あてに提出する書類の中で、「外国の送出機関が徴収する費用明細書（参考様式第2-10号）」（以下「費用明細書」という。）において明記され、徴収する費用の内容について、技能実習生に十分に理解させることを送出機関が誓約することとなっています。加えて、技能実習生の皆さんに対して、入国する前に「技能実習の準備に関し本国で支払った費用の明細書（参考様式第１-21号）」という書類にサインを求めています。これは、技能実習生の皆さんが実際に支払った費用について送出機関から十分に説明を受けて理解し、記載以外の費用が徴収されていないことを確認するためのものです。実際に支払った金額が、書類に記載されているか慎重に確認した上でサインするようにしてください。また、支払った費用の領収書等を送出機関等から発行してもらい、保管するようにしてください。後日、その領収書等が不当な手数料等の徴収を行ったことを証明する資料となる場合があります。また、送出機関等が、技能実習生及びその関係者（親族等）に対して、失踪防止などを目的として保証金を徴収すること、契約不履行について違約金を定める契約を結ぶこと、暴行等の人権を侵害する行為などを行うことについて禁止しています。以上の不適切な行為に心当たりがある場合は、すぐに機構に相談してください（115ページ参照）。

一方、技能実習法第28条第１項には、監理団体が監理事業に関し、団体監理型実習実施者等、団体監理型技能実習生等その他の関係者から、いかなる名義でも、手数料又は報酬を受けてはならないことが規定されています（ただし、その例外として、同条第２項において、監理事業に通常必要となる経費等については、あらかじめ用途及び金額を明示した上で徴収することができるとされています。これを「監理費」といいます。）。監理団体が監理費に該当しない金銭を、送出機関を含む技能実習の関係者から受け取った場合（例えば、監理団体が送出機関等からキックバックを受け取った場合）は、当該監理団体は監理団体の許可の取消しや罰則の適用対象となりますので、もし、このようなことを知った時には、機構に相談してください。

なお、これらの相談をすることによって技能実習生の皆さんが不利益に取り扱われることはありません。



7. Ур чадварын дадлагатай холбоотой сэтгэлзүйн бэлтгэл



(1) Хоногийн эхний өдөр “мэндлэх”-с эхлэнэ

Ажил дээрээ очсон бол эн түрүүнд цовоо сэргэлэн байдлаар мэндчилье.

Мэндлэх нь тухайн өдрийг сайхнаар эхлүүлэх эхлэл нь болоод зогсохгүй хоорондоо мэндэлдэг ажлын байран дээр харилцан хамтран ажиллах холбоо үүсч, өөдрөг уур амьсгал бүрддэг.

Түүнээс гадна бусадтай аль болох идэвхтэй харилцаа холбоотой байвал ажлын байран дахь харилцаа сайжран, ур чадварын дадлагын амжилтыг ахиулах ач холбогдолтой.

(2) Дүрэм журам сахих

Аж ахуйн нэгж дээр маш олон хүн ажил хийж байдаг. Тогтоосон дүрэм журмыг чанд сахиснаар ажил саадгүй урагшилна. Цаг болон амлалтыг сахиснаар та бүхэн итгэл олж авна. Тогтоосон дүрэм журмыг сахин ур чадварын дадлага удирдагч, аж амьдралын чиглүүлэг өгөх ажилтны зааварчилгааг баттай ойлгож үйлдлээ цэгнэцгээе.

(3) Нухацтайгаар зааварчилгааг хүлээн авах



Өөр зүйл бодож, хайхрамжгүй хандан, дуртай дургүй ажил хийвэл зааварчилгаа авсан зүйлээ өөрийн болгож авахгүйгээр үл барам ажлын дундуур аюул дагуулах эрсдэлтэй.

Тайлбарлаж байгаа хүний зааварчилгааг нухацтайгаар хүлээн авах нь чухал юм.

(4) Бүхий л зүйлийг ойлгох хүртэл

Ур чадварын дадлага хийх явцад гол нь ойлгохгүй, мэдэхгүй, чадахгүй чигээрээ цааш явж хэрхэвч болохгүй. Сайн ойлгоогүй хэвээр ажлаа үргэлжлүүлэн хийх нь маш аюултай юм. Ичиж зоволгүйгээр ойлгох хүртлээ олон дахин давтан нягталцгаая.

7．技能実習にあたっての心構え



(1) 一日のはじまりは「あいさつ」から

出勤したら、まずは元気にあいさつをしましょう。

あいさつをすることで気持ちのいい一日を始めることができますし、あいさつが交わされる職場では、協調性のある人間関係や明るい雰囲気が生まれてきます。

また、積極的にコミュニケーションを取ることで、職場の人間関係も良好となり、技能実習においても大きな成果を上げることが期待できます。

(2) ルールを守る

企業では、多くの人たちが働いています。スムーズに行動できるのは、決められた規則を守っているからです。時間や約束を守ることで、あなたは信頼を得るでしょう。決められた規則を守り、技能実習指導員・生活指導員の指示を確実に理解して行動しましょう。

(3) 真剣に指導を受けましょう



別のことを考えていたり、ぼんやりしていたり、いやいやながら作業をしていては、指導されたことが身につきませんし、作業中に危険を招くことにもなりかねません。

説明者の指導を、真剣に受けることが大切です。

(4) 何事もわかるまで

技能実習を進めていくうえで最も重要なことは、わからない、知らない、できないまま先に進まないことです。よくわからないまま作業を続けるのは危険です。恥ずかしがらずに理解できるまで、何回でも繰り返し確認しましょう。

8. Хууль тогтоомжийн хамаарах хүрээ

(1) Төрөл бүрийн хууль тогтоомжийн зохицуулалт

Та бүхнийг Японд байх хугацаанд дараах төрлийн хуулиуд үйлчилнэ:

Хууль тогтоолын нэр	Агуулга
Ур чадварын тухай хууль	- Ур чадварын дадлагажигч нарыг хамгаалах үүднээс дадлагажигч нарыг хариуцсан ажилтны зүгээс хориотой зүйлсийг тогтоож өгсөн байдаг. Ур чадварын дадлагажигчийн хөтөлбөрт холбогдох талууд хууль зөрчсөн тохиолдолд, ур чадварын дадлагажигч нь Хилийн шалган нэвтрүүлэх , оршин суух хяналтын газрын дарга болон Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдад мэдэгдэл өгөх эрхтэй. - Байгууллага нь ур чадварын дадлагажигч нарт зөвлөгөө өгч тусламж үзүүлэн хамгаалаар хангах тухай тогтоож өгсөн.
Хилээр гарах ба ороход хяналт тавих ба дүрвэгсдийг итгэмжлэх тухай хууль (Хилийн тухай хууль)	- Гадаадын иргэд нь Японд хуулийн дагуу оршин суухад шаардагдах эрхээс (оршин суух эрх) гадна Японд эрхэлж болох үйл ажиллагааг тогтоосон байдаг. - Таны хувьд зөвшөөрөгдсөн оршин суух эрх нь “ур чадварын дадлага” -н статус учраас үүнээс гадуур өөр ажил, тухайлбал гэрээр хийх ажил, бусад компанид цагийн ажил хийхийг хориглоно.
Хөдөлмөрийн стандартын тухай хууль Цалингийн доод хэмжээний тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	- Ур чадварын дадлагажигч нь дадлага хэрэгжүүлэгч газартай хөдөлмөрийн харилцаанд тулгуурлан ур чадварын дадлага хийх учир Япон дахь бусад ажилчдын адил Хөдөлмөрийн стандартын тухай хуулинд захирагдана (жич: Японд ирсэнээс хойш сургалтанд хамрагдах бол сургалт дууссаны дараагаар хуулинд захирагдана) - Эдгээр хууль нь хөдөлмөрийн хамгийн доод стандартыг тогтооно. Хууль зөрчсөн тохиолдолд Хөдөлмөрийн стандартын хяналтын албанд мэдүүлж болно.
Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлыг хангах тухай хууль	- Ур чадварын дадлагажигч та бүхэн хэрэгжүүлэгч байгууллагатайгаа хийсэн хөдөлмөрийн гэрээний дагуу ур чадварын дадлагажигчаар ажиллах тул, японд ажиллаж байгаа бусад хөдөлмөр эрхлэгчдийн нэгэн адил ажил олгогч нь гэрлэлт, жирэмслэлт, төрөлт зэрэг шалтгаанаар шалтаглан аажлаас халах гэх мэт зүй бус үйлдлийг эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлыг хангах тухай хуулиар хориотой. - шалтгаанаар ажлаас халагдсан бол, Нийслэл, хот мужын Хөдөлмөрийн товчоонд мэдэгдэж зөвлөгөө авна уу.
Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль Хөдөлмөрийн харилцааг зохицуулах тухай хууль	- Ур чадварын дадлагажигч та бүхэн, Японд ажиллаж байгаа бусад хөдөлмөр эрхлэгчидтэй адил үйлдвэрчний эвлэлд элсэн орж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах зэргийг шаардаж ажил олгогчтой байгууллагын хэлэлцээр хийх эрхтэй. - Дадлага хэрэгжүүлэгч газар (зарим тохиолдолд хянагч байгууллага бас) нь ур чадварын дадлагажигчийг үйлдвэрчний эвлэлд элсэн орох ба үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаагаар шалтаглаж аажлаас халах, үйлдвэрчний эвлэлээс хасахыг шаардах гэх мэт зүй ёсгүй үйлдэл хийж болохгүй. - Эдгээр байдлаар гадуурхсан тохиолдолд, хөдөлмөрийн харилцааг зохицуулах комисст тусламж хүсэж болно.
Бусад хууль тогтоомж	- Нийгмийн даатгал (эрүүл мэндийн даатгал болон тэтгэвэр), хөдөлмөрийн даатгал, татвартай холбоотой хууль тогтоомжид захирагдах болно.

Япон хөдөлмөр эрхлэгчдийн адил эдгээр хуулиар таны эрх хамгаалагдаж байгаа боловч, биелүүлэхгүй бол болохгүй үүрэг хүлээж байгаа гэдгийг бүү мартаарай.

(2) Гэмт хэрэгт холбогдохгүй байхын тулд

Сүүлийн жилүүдэд, гэмт хэргийн бүлэг гадаад оршин суугчдад зориулсан интернэтийн мэдээллэл болон SNS-н ажлын зар, найз нөхөд, танил талыг нь ашиглан янз бүрээр хуурч мэхлэн ур чадварын дадлагажигчийг гэмт хэрэгт холбогдуулж байгаа жишээ дурьдагдаж байна.

8. 法令の適用等

（1）各種法令の適用

あなたが日本に滞在する間に、次のような日本の各種法令が適用されます。

法令の名前	ポイント
技能実習法	○技能実習生を保護するため、技能実習関係者による禁止行為を定めています。技能実習関係者に法令違反があった場合には、技能実習生は出入国在留管理庁長官及び厚生労働大臣に申告することができます。 ○機構が技能実習生の相談への対応・援助・保護を行うことを定めています。
出入国管理及び難民認定法（入管法）	○外国人が日本で適法に在留（滞在）するための資格（在留資格）を規定しており、日本で行うことができる活動を定めています。 ○あなたが許可されている資格は「技能実習」ですので、この資格で認められない活動、たとえば、内職や他の会社などでアルバイトをすることはできません。
労働基準法 最低賃金法 労働安全衛生法	○技能実習生の皆さんは、実習実施者との雇用関係のもと技能実習生として働くことになりますので、日本で働く他の労働者と同じように、労働基準法などが適用されます。（なお、入国直後に講習を受ける場合は、講習終了後から適用されます。） ○これらの法律は労働条件の最低の基準を定めています。法令違反があった場合には、労働基準監督署に申告することができます。
男女雇用機会均等法	○技能実習生の皆さんは、実習実施者との雇用関係のもと技能実習生として働くことになりますので、日本で働く他の労働者と同じように、使用者が結婚・妊娠・出産等を理由として解雇など不利益取扱いをすることは男女雇用機会均等法で禁止されています。 ○このような取扱いを受けた場合は、都道府県労働局へ相談してください。
労働組合法 労働関係調整法	○技能実習生の皆さんは、日本で働く他の労働者と同じように、労働組合に加入し、労働条件の向上などを求めて使用者に対して団体交渉をする権利があります。 ○実習実施者（場合によっては監理団体も）が、技能実習生に対し、組合加入や組合活動を理由に解雇をしたり、組合脱退を求めるなどの不利益な取扱いをすることはできません。 ○これらの取扱いを受けた場合には、労働委員会に救済を求めることができます。
その他の法律	○社会保険（健康保険や年金）、労働保険、税金に関する法律なども適用されます。

これらの法令によって、日本人労働者と同じように、あなたの権利は保護されることになりますが、同じように、果たさなくてはならない義務があることも忘れないようにしてください。

（2）犯罪に巻き込まれないために

近年、犯罪組織が、外国人向けのインターネットの情報やSNSの求人広告、友人や知人からの勧誘等を使って、さまざまな犯罪に技能実習生を巻き込んでいる例が見られます。

Өөрийн нэр дээрх банкны хадгаламжын дэвтэр, бэлэн мөнгөний карт, гар утсаа бусад хүнд өгч хэрэглүүлэх, зарах.



Өөр хүний дүр эсгэж бэлэн мөнгө, дансны карт авах, мөн өөр хүний бэлэн мөнгөний картаар бэлэн мөнгө гаргаж авах.



Өөр хүний өмнөөс хүний илгээмжийг авах.



Энэ мэтийн ажил нь амар хялбар байх бөгөөд маш хурдан өндөр цалин авдаг, хөдөлмөрийн сайн нөхцөлтэй ажил юм шиг харагдаж байгаа ч бүгд цааная гэмт хэрэгт татан оруулах зам юм. Гэмт хэргийн бүлэг "Цагийн ажил хийж үзэх үү" гэх мэтээр ур чадварын дадлагажигч нарыг уран гоё үгээр хуурч уруу татдаг учир, уруу татагдсан дадлагажигч өөрсдөө ч гэмт хэрэг үйлдэж байгаагаа мэдэлгүй гэмт хэрэгт орох тохиолдол ч бий.

Ур чадварын дадлагажигч та бүхэн хэрэв дээрх аргаар гэмт хэргийн бүлэгт ашиглагдсан байсан ч, жишээлбэл, доор дурьдсан үйлдлийг гэмт хэрэг үйлдсэнд тооцож ял шийтгэл ногдуулах магадлалтай, уг нь ур чадвар эзэмшиж, гэр бүл, эх орондоо харих ёстой байтал, тэр зорилгоо биелүүлж чадалгүй, ял шийтгэл хүлээж, албадан буцаагдах хэрэг гардаг тул, иймэрхүү гэмт хэрэгт ороцолдохоос сэргийлэх хэрэгтэй.

Хэрэв, ийм зүйл сонссон харсан бол цагдаад мэдэгдэнэ үү.

Японд мөрийтэй тоглоом тоглохыг хориглодог. Танай улсад мөрийтэй тоглоом тоглохыг зөвшөөрдөг байсан ч онлайнаар тоглосон байлаа ч, Япон улсад хууль бус үйлдэл гэж үздэгийг анхаарна уу.

Мөн, та эх орондоо буцаж харих учраас өөрийн данс болон гар утсаа ашиглахаа больсон бол данс, утасны гэрээгээ цуцална уу.

・自分の預金通帳やキャッシュカード、携帯電話を他人に譲渡したり売ったりすること。



・他人になりすまして現金やキャッシュカードを受け取ること、または他人のキャッシュカードなどで現金を引き出すこと。



・他人の荷物を受け取ること。



こうした仕事は、表向きは簡単で、すぐに高額報酬を得られる好条件の仕事のように見えますが、すべて犯罪行為です。犯罪組織は、「ちょっとアルバイトをしてみないか。」などと、技能実習生の皆さんを言葉巧みに勧誘しますので、巻き込まれた技能実習生においては、自らの行為が犯罪行為であるとの自覚がないまま行っている場合もあります。

技能実習生の皆さんがこのようなかたちで犯罪組織に利用された場合であっても、例えば、下の表にあるような行為については、犯罪行為に加担したとして、罪に問われる可能性があり、本来、技能を身につけて、家族の元に無事帰国するはずが、その目的を果たすことができずに、刑事罰や強制送還等の対象となることがありますので、このような犯罪に巻き込まれないように注意してください。もし、こうした行為を見聞きしたら、警察に通報してください。

日本では賭博は禁止されています。母国で賭博が認められる場合やオンラインであっても、日本では処罰されますので注意して下さい。

また、帰国などにより銀行口座や携帯電話を利用しなくなる場合は、解約手続をしてください。

Гэмт хэрэгтэй холбогдох үйлдэл	Зүүн талд бичигдсэн үйлдэлтэй холбогдох гэмт хэргийн нэр
Өөр бусад хүнтэй хооронд банкны данс, дансны хадгаламжийн дэвтэр, бэлэн мөнгөний карт, мөнгө шилжүүлэх болон крипто хөрөнгө солилцооны үйлчилгээний акаунт мэдээлэл гэх мэтийг бусадтай төлбөртэй болон үнэ төлбөргүй шилжүүлэх, хүлээн авах.	Гэмт хэргийн ашиг орлогыг бусдад шилжүүлэхээс сэргийлэх тухай хуулийн зөрчил
Бусад хүнд гар утсаа ашиглуулах	Гар утсыг буруу ашиглахаас сэргийлэх тухай хуулийн зөрчих
Өөр хүний дүр эсгэж бэлэн мөнгө, дансны карт авах (Залилан мэхлэлийн мөнгө дамуулагч)	Залилан
ATM-с өөр хүний банкны карт ашиглаж өөр хүний нэрийн данснаас бэлэн мөнгө гаргаж авах (Залилан мэхлэлийн гар үзүүр)	Хулгай
Өөр хүний өмнөөс хүний илгээмжийг авах.	Бусдын тамгыг хуурамчаар үйлдэх
Мөрий тавьж тоглох	Мөрийтэй тоглоом

9. Оршин суугчийн үнэмлэх

Оршин суугчийн үнэмлэх нь Японд дунд болон урт хугацааны турш оршин суух гадаад иргэдэд зориулан газардах зөвшөөрөл болон оршин суух эрхийн өөрчлөгдөх зөвшөөрөл, оршин суух хугацааны шинэчлэлт зэрэг оршин суух зөвшөөрлийн хамт олгогдоно.

Та өөрийн оршин суух үнэмлэхээ биедээ авч явах үүрэгтэй учир заавал өөрөө авч явна уу. Оршин суух үнэмлэхийг хянагч байгууллага эсвэл дадлага хэрэгжүүлэгч газарт хадгалуулахгүй болно.

Түүнчлэн оршин суух үнэмлэхээ бусдад түр өгөх, дамжуулж үл болно. Буруугаар ашиглагдах, гэмт хэрэгт татагдан орох аюултай тул анхаарна уу.



Оршин суух газар
Өөрчлөгдсөн тохиолдолд ар талд нь бичигдэнэ.


Оршин суух хугацаа (дуусах хугацаа)
Япон улсад оршин суух боломжтой хугацаа тэмдэглэсэн байна.

Хөдөлмөрийн хязгаар бий эсэх
Ур чадварын дадлагаас өөр хөдөлмөр эрхлэж үл болно.

Хүчинтэй хугацаа
Оршин суух үнэмлэхэнд хүчинтэй хугацаа бий.

*2026 оны 6 сард оршин суугчийн үнэмлэхийн загвар шинэчлэгдэнэ. Мөн оршин суух үнэмлэх болон хувийн дугаарын картыг нэгтгэсэн тусгай оршин суух үнэмлэхийг авах боломжтой болно.

Гадуур ажил хийх зөвшөөрлийн хэсэг
Ур чадварын дадлагажигч олгогдсон статусаас өөр зөвшөөрөл авах боломжгүй.



“Оршин суугчийн үнэмлэхээ гээсэн бол”
Оршин суугчийн үнэмлэх нь Японд байх (амьдрах) хугацаанд таны биеийн байцаалтыг баталгаажуулах чухал бичиг баримт болно. Оршин суух үнэмлэхээ гээх, бохирдуулсан бол, өөрт ойрхон байгаа орон нутгийн Гадаадын иргэн харьяатын газарт яаралтай холбогдож зөвлөгөө авна уу.

犯罪に該当する行為	左記の行為が該当する罪名
他人との間で、銀行口座の預金通帳やキャッシュカード、資金移動・暗号資産交換サービスのアカウント情報等を有償又は無償で、譲り渡す、譲り受けること	犯罪収益移転防止法違反
他人に携帯電話を譲り渡すこと	携帯電話不正利用防止法違反
他人になりすまして現金やキャッシュカードを受け取ること（特殊詐欺における受け子）	詐欺
ＡＴＭで他人のキャッシュカードなどで他人名義の口座から現金を引き出すこと（特殊詐欺における出し子）	窃盗
他人の荷物を受け取ること	私印偽造
賭け事（ギャンブル）をすること	賭博

９．在留カード

在留カードは日本に中長期に在留（滞在）する外国人に対し、上陸許可や在留資格の変更許可、在留期間の更新許可などの在留許可に伴い交付されるものです。

あなたには在留カードを携帯する義務がありますので、必ず自分で所持してください。在留カードを監理団体や実習実施者に預けないでください。

また、在留カードを他人に貸したり、譲り渡したりもしないでください。悪用されたり、犯罪に巻き込まれたりするおそれもありますので注意してください。



住居地
変更があった場合には、裏面に記載されます。

在留期間(満了日)
日本に在留することができる期間を表しています。

就労制限の有無
技能実習以外の就労活動はできません。

有効期間
在留カードには有効期間があります。


※２０２６年６月に在留カードのデザインが新しくなります。また、在留カードとマイナンバーカードがひとつになった特定在留カードの交付を受けることができるようになります。

資格外活動許可欄
技能実習生は、資格外活動許可を受けることはできません。



【在留カードを紛失等した場合】
在留カードは、日本に在留（滞在）中のあなたの身分を証明する重要な証明書となります。
在留カードをなくしたり、汚してしまった場合は、速やかに最寄りの地方出入国在留管理局に相談してください。

10. Ур чадварын дадлагыг хийхэд бэрхшээлтэй болсон тохиолдолд



(1) Ур чадварын дадлага түр зогссоны дараах дахин үргэлжлүүлэх тухай

Үндсэндээ, ур чадварын дадлагыг дадлагажигч нэг бүрд боловсруулсан төлөвлөгөөний дагуу тасралтгүй хэрэгжүүлэх ёстой байдаг.

Гэвч, өнгөрсөн хугацаанд ур чадварын дадлагажигч эрх зүйг зөрчин, ур чадварын дадлагын төлөвлөгөө дуусахаас өмнө нутаг буцаах хууль бус үйлдэл мэр сэр гарч байлаа.

Тийм учраас ур чадварын дадлагын хуулиар хэрэгжүүлэгч газрын менежментийн нөхцөл байдал, дадлагажигчийн өвчин болон гэмтлийн (ажлаа гүйцэтгэж яваад гэмтэх зэрэг орно.) улмаас ур чадварын дадлагаа үргэлжлүүлэх нь бэрхшээлтэй болсон бол хянагч байгууллагын (цаашид хянагч байгууллага гэх) зүгээс ур чадварын дадлага гүйцэтгэхэд бэрхшээлтэй болсон гэсэн мэдэгдлийг Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагад гаргаж өгөх ёстой.

Тухайн үед, ур чадварын дадлагажигч нь ур чадварын дадлагын төлөвлөгөөний явц дунд нутаг буцахаар болсон тохиолдолд, хяналтын байгууллага гэх мэт нь ур чадварын дадлагажигчид өөрийн хүсэл зоригийн эсрэг нутаг буцах шаардлагагүй болохыг тайлбарлаж, нутаг буцах эсэх талаарх хүсэл зоригийг нь бичгээр баталгаажуулан, уг бичгийг гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагад хүргүүлэх ёстой гэж заасан байна (*).

Ур чадварын дадлагажигч нь өвчин, гэмтэл (оролцуулна), ур чадварын дадлагажигчийн гэр бүлийн нөхцөл байдал эсхүл өөрөө жирэмсэн болох, төрөлт зэрэг шалтгааны улмаас ур чадварын дадлагыг үргэлжлүүлэх боломжгүй болж, нэг удаа нутаг буцсан тохиолдолд ч, ур чадварын дадлагажигч нь ур чадварын дадлагыг цаашид үргэлжлүүлэхийг хүсвэл, дахин ур чадварын дадлагыг сэргээж эхлүүлэх боломжтой. Үргэлжлүүлэхийг хүсэж байгаа тохиолдолд хяналтын байгууллага гэх мэт эсхүл гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагад хандан зөвлөгөө авна уу.

* Хэрэв таны (ур чадварын дадлагажигч) өөрийн хүсэл зоригийн эсрэг нутаг буцахыг шаардуулсан тохиолдолд, гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагад хандан зөвлөгөө авах эсхүл өргөдөл гаргах боломжтойгоос гадна, ямар нэгэн шалтгаанаар нисэх онгоцны буудал зэрэг газарт хүргэгдсэн байсан ч, Япон улсаас гарах бүртгэлийн үеэр цагаачлалын албан хаагчид энэ талаар мэдэгдэх боломжтой.

(2) Зайлшгүй шалтгаан байгаа тохиолдолд дадлагажих байгууллагыг өөрчлөх зэрэг асуудлын тухай

а) Дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхийг зөвшөөрч болох зайлшгүй шалтгааны тухай

Одоогийн дадлагажих байгууллагад ур чадварын дадлагыг үргэлжлүүлэх нь ур чадварын дадлагыг зохих ёсоор хэрэгжүүлэх болон ур чадварын дадлагажигчийг хамгаалах гэсэн зорилгод нийцэхгүй гэж үзэхийц зайлшгүй шалтгаан байгаа тохиолдолд, дадлагажих байгууллагыг өөрчлөх боломжтой. Зайлшгүй шалтгааны улмаас ур чадварын дадлагыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирсан тохиолдол гэдэг нь, жишээлбэл дараах нөхцөл байдалд хамаарах боловч, ойлгохгүй байгаа тохиолдолд хянагч байгууллага эсвэл гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагад хандан баталгаажуулна уу.

Дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхийг зөвшөөрч болох зайлшгүй нөхцөл байдал


- Дадлага хэрэгжүүлэх газрын менежмент болон бизнесийн нөхцөл байдлаас(дампуурал, үйл ажиллагаа зогсох, бизнесийн хүрээгээ багасгах зэрэг)шалтгаанаас болж дадлага хэрэгжүүлэх газраас хөдөлмөрийн харилцааг цуцалсан тохиолдолд
- Танд (ур чадварын дадлагажигч) цалин хөлс олгохгүй байх зэрэг, дадлага хэрэгжүүлэх газар нь танд (ур чадварын дадлагажигч) ур чадварын дадлагыг хэрэгжүүлэх явцад хууль тогтоомжийг санаатайгаар ноцтой зөрчсөн тохиолдолд
- Дадлага хэрэгжүүлэх газарт хүчирхийлэл, төрөл бүрийн дарамт(эрх мэдлээр дарамтлах, бэлгийн дарамт үзүүлэх, жирэмсний дарамт) зэрэг хүний эрхийг зөрчсөн үйлдэл гарсан тохиолдолд
- Таны (ур чадварын дадлагажигчийн) хөдөлмөрийн нөхцөл болон ажлын хангамж нь Япон улсад нэвтрэхээс өмнө та (ур чадварын дадлагажигч) дадлага хэрэгжүүлэх газартай байгуулсан гэрээний агуулгатай ихээхэн зөрүүтэй байж, дадлага хэрэгжүүлэх газарт зөрчлийг засах хүсэлт гаргасан боловч засаж сайжруулах арга хэмжээ авагдаагүй тохиолдолд

и) Дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхөд үзүүлэх дэмжлэг зэрэг асуудлын тухай

Дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхөд үзүүлэх дэмжлэгийг хянагч байгууллага гэх мэт нь үзүүлнэ. Хянагч байгууллага гэх мэтээс дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөх талаар зөвлөгөө авах үед дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөх хүсэлтийг гаргах зориулалттай маягт [Дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөх хүсэлтийн мэдүүлэг (лавлах маягт №1-44)]–ийг ашиглана уу. (Доорх URL-ийг үзнэ үү №1-44).

Хянагч байгууллага гэх мэт нь дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхгүй тохиолдолд, гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага нь дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэх тул холбогдон зөвлөгөө авна уу.

10. 技能実習を行うことが困難になった場合



（1）技能実習中断後の再開について

本来、技能実習は、技能実習生ごとに作成された技能実習計画に従い、途中で中止されることなく実施されなければなりません。

しかし、過去には、一部で技能実習生の意に反し、技能実習計画満了前に帰国させられるという事案が発生していました。

そのため、技能実習法においては、実習生の経営上の都合、技能実習生の病気や怪我（業務上の怪我などを含む。）の事情等で技能実習の実施が困難となった場合には、監理団体及び実習先（以下「監理団体等」という。）は技能実習実施困難時届出書を機構に提出することを求めています。

その際、技能実習生が技能実習計画の途中で帰国することとなった場合に、監理団体等は技能実習生に対し、意に反して帰国する必要がないことの説明や、帰国の意思確認を書面で行い、その書面を機構に提出しなければならないとされています(※)。

技能実習生の病気・怪我（労災含む。）、技能実習生の家族の都合や自身の妊娠・出産等により技能実習の実施が困難となり、一度帰国した場合でも、技能実習生が技能実習の継続を希望する場合には、改めて技能実習を再開することができます。継続を希望される場合は、監理団体等又は機構までご相談ください。

※あなた（技能実習生）の意思に反して帰国を促された場合にあっては、機構に相談や申告の申出を行うことができるほか、万が一、空港などに連れてこられたときでも、出国手続の際に入国審査官にその旨を申し出ることができます。

（2）やむを得ない事情がある場合の実習先変更等について

ア）実習先変更を認め得るやむを得ない事情について

現在の実習先で技能実習を継続することが、技能実習の適正な実施及び技能実習生の保護という趣旨に沿わないと認められるやむを得ない事情があった際は、実習先を変更できる可能性があります。

やむを得ない事情で技能実習の実施が困難になった場合とは、例えば次のようなものが当てはまりますが、分からない場合には監理団体等又は機構に確認してください。

《実習先の変更を認め得るやむを得ない事情》

・実習先の経営上・事業上の都合（倒産、廃業、事業縮小など）により、実習先から雇用関係を打ち切られたとき

・あなた（技能実習生）に対する賃金不払いなど、実習先があなた（技能実習生）に対し、技能実習を行う上で、重大悪質な法令違反行為を行ったとき

・実習先で、暴行、各種ハラスメント（パワーハラスメント、セクシュアルハラスメント、マタニティハラスメント）などの人権侵害行為があったとき

・あなた（技能実習生）の労働条件や待遇が、入国前にあなた（技能実習生）が実習先と契約した内容と大きく異なっていて、実習先に是正を求めても是正されないとき

イ）実習先変更の支援などについて

実習先変更の支援は監理団体等が行います。監理団体等に実習先変更を相談する際は、実習先変更を申し入れるための用紙【実習先変更希望の申出書（参考様式第1－44号）】を活用してください（下記ＵＲＬ参照）。

監理団体等が実習先変更の支援に応じてくれない場合は、機構において実習先変更の支援を行いますのでご相談ください。

実習先変更のための手続を行っている間に、生活費を確保する必要がある場合には、地方出入国在留管理局で手続すると週２８時間以内に限りアルバイトを行うことが可能となります。詳しくは最寄りの地方出入国在留管理局までご相談ください。

Дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхтэй холбоотой журмыг хэрэгжүүлэх хугацаанд, амьжиргааны зардлыг хангах шаардлага гарсан тохиолдолд, орон нутгийн цагаачлал оршин суух хяналтын газарт холбогдох материалын бүрдүүлэлтийг хийснээр долоо хоногт 28 цагаас хэтрэхгүй хэмжээнд хагас цагийн ажил хийх боломжтой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг өөрт ойрхон орон нутгийн цагаачлал оршин суух хяналтын газартай холбогдож зөвлөгөө авна уу.

Мөн үүнээс гадна, ур чадварын дадлагыг үргэлжлүүлэхийг хүсэж байгаа боловч, зайлшгүй шалтгааны улмаас дотуур байранд байрлах боломжгүй болсон тохиолдолд, гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагаас түр хугацаанд байрлах газраар хангах боломжтой. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг, гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагад хандан зөвлөгөө авна уу.

[Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагын вэб сайт　Зайлшгүй шалтгааны улмаас дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөх]
https://www.otit.go.jp/trainee/ja/howto/transfer/

[Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагын вэб сайт　Дадлага хэрэгжүүлэх газрыг өөрчлөхөд үзүүлэх дэмжлэг]
https://www.support.otit.go.jp/jisshu/jp/index.html

11. Нутаг буцаах арга хэмжээ авагдах гэж байгаа бол

Хянагч байгууллага болон дадлага хэрэгжүүлэгч газрын нэг талын нөхцөл байдлаас шалтгаалан ур чадварын дадлагажигчийг дадлага хийж байх хугацаанд дадлагажигчийн хүслийг үл ойшоож нутаг буцаахыг зөвшөөрөхгүй. Хэрэв таны хүслийг үл ойшоож нутаг буцах арга хэмжээ авагдах гэж байгаа бол манай байгууллагатай зөвлөлдөж, мэдэгдэл саргана уу.

Мөн, дадлагажих хугацааны дундуур эх орондоо буцах тохиолдолд (Япон руу дахин орохоор төлөвлөж байгаагаас бусад тохиолдолд) нисэх онгоцны буудал дээр хилийн байцаагч танаас нутаг буцаах арга хэмжээ авагдсан эсэхийг лавлах тул хэрэв таны хүслийг үл ойшоон нутаг буцаах гэж байгаа бол үүнийгээ хилийн байцаагчид мэдэгдэнэ үү.

12. Ур чадварын дадлагын хугацаанд гэрлэх, жирэмслэх, төрөх тохиолдолд

Ур чадварын дадлагажигчийн хувийн амьдралыг шударга бусаар хязгаарлаж, гэрлэх, жирэмслэх, хүүхэд төрүүлэх гэх мэт шалтгаанаар ажлаас нь халахыг хуулиар хориглодог. Үүнээс гадна, хэрэв та жирэмсэн болсон эсвэл хүүхэд төрүүлсэн бол хуулийн дагуу жирэмсний амралтаа авах боломжтой. Хууль бус шалтгаанаар ажлаас халагдсан эсвэл өөр тодруулах зүйл байвал Нийслэл, хот мужын хөдөлмөрийн товчоонд хандана уу. Та манай байгууллагатай зөвлөлдөж, эх хэлээр зөвлөгөө авч, мэдүүлэг гаргаж болно (42, 46 хуудсыг үзнэ үү).

このほか、技能実習を続けることを希望しているものの、やむを得ない事情により宿舎に宿泊することができない場合は、機構による一時宿泊先の提供を受けることもできます。詳しくは、機構に相談してください。

【外国人技能実習機構ホームページ　やむを得ない事情がある場合の実習先変更】
https://www.otit.go.jp/trainee/ja/howto/transfer/

【外国人技能実習機構ホームページ　実習先変更支援サイト】
https://www.support.otit.go.jp/jisshu/jp/index.html

11. 帰国を強制されそうになった場合

監理団体や実習実施者の一方的な都合により、技能実習生が実習期間の途中で、その意に反して、帰国させられることは許されません。もし、皆さんが、意に反して帰国を強制されそうになった場合には、機構に相談や申告の申出を行ってください。

また、**実習期間の途中で本国に帰国するようなケース（再入国の予定がある場合を除く。）においては、空港などでの出国手続において、入国審査官が、皆さんに対して、強制帰国ではないかどうか確認をとりますので、意に反して帰国させられそうになっている場合には、その旨を申し出てください。**

12. 技能実習中に結婚・妊娠・出産などをした場合

技能実習生の私生活の自由を不当に制限することや結婚・妊娠・出産などを理由として、解雇など不利益な取扱いをすることは法律で禁止されています。また、妊娠・出産した場合は、法律に基づく産前産後の休業などの対象となります。不利益な取扱いを受けた場合や不明なことがある場合は、都道府県労働局へ相談してください。機構又は母国語相談に相談や申告の申出もできます(43、47ページ参照)。

Ажиллаж буй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд зориулсан төрөлт, хүүхэд асрахтай холбоотой систем

- [Илүү цагаар ажиллах, амралтын өдөр ажиллуулах, шөнийн цагаар ажиллах зэрэгт хязгаарлалт тавьдаг]
  Жирэмсэн болон хүүхэд төрсний дараа эхний 1 жилийн дотор илүү цагаар ажиллах, амралтын өдөр ажиллах, шөнийн цагаар ажиллах аажлаас чөлөөлөх хүсэлт гаргаж болно. Өөрчлөгдсөн аажлын цагийн систем батладаг байсан ч гэсэн нэг өдөр, нэг долоо хоногт хуулиар тогтоосон аажлын цагаас хэтэрч ажиллуулахгүй байхыг шаардаж болно.
- [Хялбар аажлаар сольж хөнгөвчлөх]
  Жирэмсэн үед та өөр бусад биед ачаалалгүй ажилд шилжүүлэх хүсэлт гаргаж болно.
- [Жирэмсний амралт]
  Төрөх өдрөөс 6 долоо хоногийн өмнө (ихэр байх тохиолдолд 14 долоо хоногийн өмнө) хүсэлт гаргаж авах боломжтой. Хүүхэд төрөх өдөр нь жирэмсний амралтанд багтдаг.
- [Төрсний дараах амралт]
  Хүүхэд төрүүлсэн өдрийн дараагийн өдрөөс хойш 8 долоо хоног ажиллах боломжгүй. Гэсэн хэдий ч, төрснөөс хойш 6 долоо хоног өнгөрсний дараа тухайн хүний хүсэлтээр, эмч ямар ч асуудал байхгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн бол ажиллаж болно.
- [Аажлаас халах хязгаарлалт]
  Хүүхэд төрөхөөс өмнө болон дараах хугацаа болон түүнээс хойш 30 хоногийн дотор аажлаас халахыг хориглоно.
- [Хүүхэд асрах цаг]
  Нэг нас хүрээгүй хүүхдийг өсгөж буй эмэгтэй өдөрт хоёр удаа хамгийн багадаа 30 минут хүүхэд асрах цаг гаргаж өгөхийг шаардаж болно.
- [Эх, үрийн эрүүл мэндийн хяналт]
  Та жирэмсний үзлэгт хамрагдах цаг гаргаж өгөхийг шаардаж болно.
  Жирэмсний үзлэгт хамрагдаж, эмчийн зааврыг авч байгаа бол зааврыг дагаж мөрдөхөд шаардлагатай арга хэмжээг авч, хүсэлт гаргаж болно.
  Төрсний дараа 1 жилийн дотор эмчийн зааврааар эмчийн үзлэгт хамрагдах шаардлагатай бол эмчийн үзлэгт үзүүлэхэд чөлөө өгөхийг шаардаж болно.
- [Хүүхэд асрах чөлөө]
  Нэг нас хүрээгүй хүүхдээ өсгөхийн тулд эрэгтэй, эмэгтэй ажилчид аажлаасаа чөлөө авах хүсэлт гаргаж болно. Түүнчлэн, ямар нэг шалтгаанаар цэцэрлэгт хамрагдах боломжгүй бол 2 нас хүртэл чөлөө авах боломжтой.
- [Хүүхэд төрсний дараа эцэгчүүдэд олгох хүүхэд асрах чөлөө (Хүүхэд төрөх үед хүүхэд асрах чөлөө)]
  Хүүхдээ төрснөөс хойш 8 долоо хоногийн хугацаанд, 4 долоо хоног хүртэлх хугацааг хоёр хувааж чөлөө авах хүсэлт гаргаж болно.
- [Богино цагаар ажиллах систем]
  Тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд эрэгтэй, эмэгтэй ажилчид 3-аас доош насны хүүхдээ өсгөхийн тулд богино цагаар ажиллах (зарчмын хувьд өдөрт 6 цаг) хүсэлт гаргаж болно.
- [хязгаарлах (Илүү цагаар ажиллахаас чөлөөлөх)] хязгаарлах, шөнийн цагийн ажилыг хязгаарлах]
  Тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд эрэгтэй, эмэгтэй ажилчид бага сургууль эсэхийн өмнөх хүүхдээ өсгөхийн тулд, болон шөнийн цагийн ажлыг хязгаарлах хүсэлт гаргаж болно.
- [Хүүхэд асрах гэх мэт чөлөө]
  Бага сургуулийн 3-р ангийг төгсөх хүртэл хүүхдээ өсгөхийн тулд эрэгтэй, эмэгтэй ажилчид тус компанид мэдэгдсэнээр жилийн цалинтай амралтаас гадна, жилд 5 хоног, хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй бол 10 хоногийн чөлөө авч болно, өвдөж бэртсэн хүүхдээ асарч сувилах, вакцин хийлгэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, халдварт өвчний улмаас хичээл хаах мөн цэцэрлэгт орох (сургуульд элсэх) ёслол болон цэцэрлэг төгсөх ёслолд оролцохын тулд чөлөө авч болно. Чөлөө авахдаа өдрөөр эсвэл цагаар авна.

働く女性・男性のための出産・育児に関する制度

・【時間外労働、休日労働、深夜業の制限】
妊娠中及び出産後１年以内の女性は、時間外労働、休日労働、深夜業の免除を請求できます。変形労働時間制が取られる場合にも、１日及び１週間の法定労働時間を超えて労働しないことを請求できます。
・【軽易業務転換】
妊娠中は、他の軽易な業務への転換を請求できます。
・【産前休業】
出産予定日の６週間前（双子以上の場合は14週間前）から、請求すれば取得できます。出産当日は産前休業に含まれます。
・【産後休業】
出産日の翌日から８週間は、就業することができません。ただし、産後６週間を経過後に、本人が請求し、医師が支障がないと認めた業務には就業できます。
・【解雇制限】
産前・産後休業の期間及びその後30日間の解雇は禁止されています。
・【育児時間】
生後１年に達しない子を育てる女性は、１日２回各々少なくとも30分間の育児時間を請求できます。
・【母性健康管理】
妊婦健診を受けるための時間を確保することを請求できます。
妊婦健診を受け、医師等から指導を受けた場合は、指導事項を守ることができるようにするための必要な措置を申出・請求できます。
出産後１年以内の女性は、医師等から指示があったときは、健康診査等に必要な時間の確保を申し出ることができます。
・【育児休業】
１歳未満の子を養育するために、男女労働者は、休業を申し出ることができます。また、保育所に入所できない等の理由がある場合は、最大２歳まで取得できます。
・【産後パパ育休（出生時育児休業）】
子の出生から８週間までの期間で、４週間までを２回に分けて休業を申し出ることができます。
・【短時間勤務制度】
一定の条件を満たす場合、3歳未満の子どもを育てるために、男女労働者は、短時間勤務（1日原則として6時間勤務）を請求できます。
・【所定外労働の制限（残業免除）、時間外労働の制限、深夜業の制限】
一定の条件を満たす場合、小学校就学前の子を育てるために、男女労働者は、所定外労働の制限、時間外労働の制限及び深夜業の制限を請求できます。
・【子の看護等休暇】
小学校第３学年修了までの子どもを養育するために、男女労働者は、会社に申し出ることによって、年次有給休暇とは別に、1年につき5日間、子どもが2人以上なら10日間、病気やけがをした子どもの世話、予防接種、健康診断、感染症に伴う学級閉鎖並びに入園(入学)式及び卒園式への参列のために休暇を取得することができます。また、取得単位は1日又は時間単位です。

Жирэмсэн болсон гэдэг шалтгаанаар ажлаас нь халах арга хэмжээ авагдах эсвэл нутаг буцаах гэж байгаа бол эхлээд манай байгууллага эсвэл эх хэлээр зөвлөгөө өгөх газартай зөвлөлдөж, мэдүүлэг гаргана уу.

Төрсний дараа зарчмын хувьд 8 долоо хоног ажиллах боломжгүй, гэхдээ үүний дараа та дахин дадлагаа үргэлжлүүлж болно. Түүнчлэн дадлагаа тасалдуулж, эх орондоо харьж амаржсан тохиолдолд ч, дахин хилээр орж, дадлагаа үргэлжлүүлэх боломжтой. Ур чадварын дадлагаа дахин эхлүүлэхийн тулд манай байгууллагад хандах шаардлагатай. Ур чадварын дадлагаа дахин эхлүүлэх хүсэлтэй байгаагаа болон дахин эхлүүлэх хугацааг хэналтын байгууллага, дадлага хэрэгжүүлэгч газарт мэдэгдэнэ үү.

Жирэмсэн гэдгээ мэдмэгц, оршин суугаа газрынхаа хотын захиргаанд очиж, аль болох хурдан “жирэмсний мэдэгдэл” мэдүүлнэ үү. Мэдүүлэг мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримтууд нь ихэвчлэн жирэмсний мэдүүлгээс гадна хувь хүний биеийн байцаалт (оршин суух үнэмлэх), хувийн дугаарыг баталгаажуулах бичиг баримт (Миний дугаарын карт г.м) байдаг ч, хот дүүргээс хамаарч өөр өөр байдаг тул, хотын захиргааны вэб сайтаас урьдчилан шалгах шаардлагатай.

Жирэмсэн гэдгээ мэдүүлсний дараа, хот суурин газраас эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр олгоно. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр нь эхчүүдэд жирэмслэлтээс эхлээд төрсний дараах үе, нярайгаас эхлээд балчир нас хүртэлх эрүүл мэндийн байдлыг тогтмол тэмдэглэхэд ашиглахын зэрэгцээ нярай болон бага насны эцэг эхчүүдэд зориулсан хүүхэд өсгөн хүмүүжүүлэх гарын авлага гэж хэлж болно. Олгох газрыг хот, дүүргийн вэб сайтаас олж мэдэх боломжтойгоос гадна зарим хот, дүүргээс эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрийг гадаад хэлээр гаргах тохиолдол бий. Түүнчлэн, эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр олгохооос гадна жирэмсний үзлэгт хамрагдах хөнгөлөлттэй эрхийн бичиг олгох, нийгмийн эрүүл мэндийн ажилтантай зөвлөлдөх, ээж, эцэг эхчүүдэд зориулсан сургалтанд хамрагдах, бусад олон төрлийн мэдээлэл авах боломжтой. Мөн, жирэмсэн эхчүүдэд зориулсан тэтгэмж (жирэмсэн үед 50,000 иен, эхийн хэвлийд байгаа хүүхдийн тоо × 50,000 иен). Зулбасан, нас барсан тохиолдолд ч тэтгэмжийн нөхөн олговор олгоно.)-г авах эрхтэй.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрийн мэдээллийг дэмжих сайт (https://mchbook.cfa.go.jp/)-д эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрийг олон хэлээр (10 хэлээр) гаргахаас гадна, Японд жирэмсэлж, хүүхэд төрүүлэн өсгөх үйл явцын тайлбар, анхаарах зүйлсийг нэгтгэсэн таниулга хуудсыг байршуулдаг.

Хүүхэд төрөх үед, төрсөн өдрөөс хойш 14 хоногийн дотор шинээр төрсөн хүүхдийн төрсөн хот, дүүрэг болон шинээр төрсөн хүүхдийн оршин суугаа харьяа газар эсвэл эцэг эхийн оршин суугаа хотын захиргааны аль нэгэнд шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлэх ёстой. Төрсний бүртгэл хийлгэхийн тулд эмчийн бичсэн төрсний гэрчилгээтэй байх шаардлагатай.

Түүнчлэн, аав ээж нь гадаадын иргэн бол, шинээр төрсөн хүүхэд Японд төрсөн байсан ч, Японы иргэншил авах боломжгүй. Ийм тохиолдолд, өөрийн эх оронд нь шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлнэ үү. Дэлгэрэнгүй мэдээллийг аав ээжийнхээ харьяат улсын элчин сайдын яам эсвэл консулын газартай холбоо барьж лавлана уу.

Мөн, төрснөөс хойш 60 хоногоос дээш хугацаагаар Японд байхаар төлөвлөж байгаа бол оршин суух статус авах шаардлагатай. Жирэмсэн, төрөлтөөс шалтгаалан дадлага хийхээ түр зогсоох тохиолдолд оршин суух статустай холбогдох өргөдлийн талаар өөрт ойрхон байрлах орон нутгийн Гадаад иргэн харьяатын газартай зөвлөлдөнө үү.

妊娠したことを理由に解雇されそうになったり帰国するよう言われたりしたら、まずは、機構又は母国語相談に相談や申告の申出を行ってください。

出産後、原則８週間は仕事をすることができませんが、その後技能実習を再開することができます。また、技能実習を中断し、帰国して出産した場合も、再度入国して技能実習を再開することができます。技能実習の再開は、機構などで手続が必要です。技能実習の再開や再開時期の希望を監理団体・実習実施者に伝えてください。

妊娠が分かった際は、お住まいの市区町村の窓口で、速やかに「妊娠の届出」を行ってください。届出に際して必要な書類としては、妊娠届出書のほか、本人確認書類（在留カード等）や個人番号確認書類（マイナンバーカード等）が代表的ですが、市区町村によって異なっているため、事前に市区町村のホームページ等で確認しておくことが必要です。

妊娠の届出を行うと、市区町村から母子健康手帳が交付されます。母子健康手帳は、母親の妊娠期から産後まで、子どもの新生児期から乳幼児期までの健康状態を一貫して記録することができるものであるとともに、乳幼児の保護者に対する育児に関する指導書であるともいえます。交付窓口は、市区町村のホームページ等で確認することができるほか、市区町村によっては、外国語の母子健康手帳を交付している場合もあります。さらに、窓口では、母子健康手帳の交付とともに、妊婦健診を公費の補助で受けられる受診券や、保健師等による相談、母親学級・両親学級の紹介、各種の情報提供などを受けることができます。また、妊婦のための支援給付（妊娠時５万円・妊娠後期以降に妊娠しているこどもの人数×５万円。流産・死産の場合も対象となります。）を受け取ることもできます。

母子健康手帳情報支援サイト（https://mchbook.cfa.go.jp/）では、母子健康手帳を多言語化（10か国語）しているほか、日本における妊娠から子育てまでの一覧の流れの説明や注意すべき点等のポイントをまとめたリーフレット等を掲載しています。

子どもが生まれた際は、出生後１４日以内に子どもが生まれた市区町村、子どもの本籍地の市区町村又は届出人が居住する市区町村のいずれかに出生届を提出しなければなりません。出生届の提出には、医師等が発行する出生証明書が必要となります。

なお、父も母も外国の国籍である場合、その子どもが日本で生まれたとしても、日本国籍を取得することはできません。このような場合、子どもが生まれたことについて本国へ届け出る手続をしてください。詳しい手続については、父又は母の国籍国の駐日大使館・（総）領事館に問い合わせてください。

また、出生から６０日間を超えて日本に在留しようとする場合、在留資格を取得する必要があります。妊娠・出産に伴い技能実習を一時中断する場合を含め、在留資格取得申請については、最寄りの地方出入国在留管理局において御相談ください。

13. Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллагаас үзүүлэх зөвлөгөө (Байгууллагын лавлах газар)

Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага нь ур чадварын дадлагажигч та бүхэнд дараах лавлагааг (доор бичигдсэн байгаа жишээ) эх хэл дээр нь өгөх тул заавал хэрэглэнэ үү.

Үнэгүй дуудлага хийнэ. Ойролцоох нийтийн утаснаас 10 иенээр залгах боломжтой. Ярьж дууссаны дараа та үлдсэн мөнгөө буцааж авах болно.

[Нийтийн утас суурилуулсан газрын хайлт]

Зүүн япон: https://publictelephone.ntt-east.co.jp/ptd/map/

Баруун япон: https://www.ntt-west.co.jp/ptd/map/

- Хэрэгжүүлэгч газар, удирдлагад үүссэн гэнэтийн шалтгаанаас үүдэн хэрэгжүүлэгч газрыг солих хэрэгтэй тохиолдолд дэмжлэг үзүүлнэ.
- Хяналтын байгууллага нь байрлах байраар хангахаас татгалзах зэрэг тусламж хэрэгтэй тохиолдолд хандана уу.
- Хяналтын байгууллага болон дадлага хэрэгжүүлэгч газар нь Ур чадварын дадлагын тухай хууль зөрчсөн тохиолдолд мэдүүлэг өгөх болон тусламж хэрэг болоход хүлээн авна.
- Зарчмын хувьд ур чадварын дадлагажигч дадлагын сургалтад хамрагдаад эх орондоо буцах замын зардлыг хяналтын байгууллага бүрэн төлөх ёстой. Хэрэв та буцах замын зардлаа авч чадахгүй эсвэл танаас зардлынхаа тодорхой хэсгийн төлөхийг шаардсан бол бидэнтэй зөвлөлдөнө үү.

“Авч болох лавлагаа”

- Японд ирэхийн өмнө, илгээгч байгууллага хангалттай тайлбаргүйгээр япон явах замын зардал гаргуулах, барьцаа мөнгө авах, торгуулийн гэрээ байгуулах зэрэг зохисгүй үйлдэл гарсан үед
- Дадлагын хугацаа дуусаагүй байхад, үргэлжлүүлэн дадлага хийх хүсэлтэй байтал, нутаг буцаах арга хэмжээ авагдсан тохиолдолд
- Амьдрах газар болон өдөр тутмын хоол хүнсээр дутагдсан бол
- Ажил болон өдөр тутмын амьдрал дээр саналаа зовох зүйл гарсан бол
- Шашин шүтлэг, хоол, ёс заншил, сэтгэлгээ зэрэгт зөвлөгөө авах хэрэгтэй бол
- Цалин хөлс, илүү цагийн ажил зэрэг хөдөлмөрийн нөхцөлд эргэлзээтэй бол
- Ур чадварын дадлага хийж байгаа газар өгч байгаа зааварчилгааг ойлгохгүй байх, амьдралын хэв маяг, сэтгэлгээний ялгаатай байдлаас болон асуудал тулгарсан бол
- Хэрэгжүүлэгч газар Ур чадварын дадлагын тухай хуулийг зөрчсөн гэж үзвэл

  Тухайлбал:
  - Аялалын тасалбар болон оршин суугчийн үнэмлэх, дансны дэвтрээ хураалгасан бол
  - Гадагш гарахад зүй бусаар хязгаарлах
  - Хувийн амьдралын эрх чөлөөнд зүй бусаар хязгаарлалт тогтоовол (гар утастай байхыг хориглох гэх мэт)
  - Ур чадварын дадлагын агуулга нь тайлбартай зөрөх
  - Хүч хэрэглэх эсвэл заналхийлэх зэрэг байдлаар ур чадварын дадлага хүчээр хийлгэж байгаа
  - Дээрэлхэх, эрх мэдлээр дарамтлах зэрэг хүний эрхийн зөрчилд өртөх үед
  - Өөрийн хүслийн эсрэг нутаг буцаах гэх
- Хэрэгжүүлэгч газрын удирдлагын боломжоос шалтгаалан дадлага үргэлжлүүлэх боломжгүй болсон ба хянагч байгууллагаас шинэ ажил хайхад дэмжлэг үзүүлэхгүй байх
- Ур чадварын дадлагын 3-р зэрэг авахтай холбогдуулан дадлага хэрэгжүүлэгч газраа өөрчлөхийг хүсч байгаа боловч хянагч байгууллагаас шинэ газар хайж өгөхөд туслахгүй байх үед
- Ур чадварын дадлагын тогтолцооны талаар ойлгохгүй зүйл байвал
- Японы хууль, олон төрлийн тогтолцооны талаар хаанаас лавлахаа мэдэхгүй бол



13. 外国人技能実習機構における相談【母国語相談】

機構では、技能実習生の皆さんから、次のような相談（相談例参照）を母国語で受け付けていますので、是非御活用ください。

通話料は無料です。近くの公衆電話から10円玉でかけられます。通話が終わればお金は戻ってきます。

【公衆電話設置場所検索】

東日本　https://publictelephone.ntt-east.co.jp/ptd/map/

西日本　https://www.ntt-west.co.jp/ptd/map/

○実習先の経営上の都合等によりやむを得ない事情で実習先の変更が必要なときの支援を行っています。

○監理団体等が宿舎の提供を拒む場合など支援を受けたい場合も御相談ください。

○監理団体や実習実施者の技能実習法令違反についての申告や相談も受け付けています。

○技能実習終了後の帰国旅費については、原則、監理団体が全額支払う必要があります。もし、帰国旅費を払ってもらえなかったり、その一部の負担を求められたりした場合には相談してください。

【相談例】

- 入国前に、送出機関等から、十分な説明がないまま来日費用を徴収されたり、保証金を徴収されたり、違約金契約を結ばされたりするなど、不適切な行為があったと感じたとき
- 実習が修了していなくて、実習を続けたいのに帰国させられそうになったとき
- 住む場所や毎日の食事に困っているとき
- 仕事上や日常生活で悩みや不安を感じたとき
- 宗教、食事、習慣、考え方に関するアドバイスがほしいとき
- 賃金や時間外労働等の労働条件等で疑問をもったとき
- 技能実習の現場で指示が理解できなかったり、生活習慣や考え方の違いからトラブルになったりしたとき
- 実習先で技能実習法令に違反があると感じたとき

  例えば、
  - 旅券や在留カード、通帳を取り上げられているとき
  - 外出を不当に制限されているとき
  - 私生活の自由を不当に制限されているとき（携帯電話の所持が禁止されているなど）
  - 技能実習の内容が説明を受けていたものと違うとき
  - 暴行や脅迫等の手段で技能実習を強制されているとき
  - いじめやパワハラなど、人権侵害行為を受けているとき
  - 意に反して帰国させられそうなとき
- 実習先の経営上の都合などで実習を続けられなくなったが、監理団体が新たな実習先を探すことに協力してくれないとき
- 技能実習３号に移行する際に、実習先の変更を希望しているが、監理団体が新たな実習先を探すことに協力してくれないとき
- 技能実習制度に関して分からないことがあるとき
- 日本の法律、各種制度に関して相談先が分からないとき



Лавлахын нэр (арга)	Холбоо барих хаяг, ямар хэлээр үйлчилгээ үзүүлдэг	Ажиллах цагийн хуваарь (Долоо хоног бүр)	Тайлбар
Эх хэл дээр утсаар зөвлөгөө өгөх (утас)	**Утас: 0120-250-168** Ямар хэлээр үйлчилдэг: Вьетнам хэл	Даваа гараг-Баасан гараг 11:00-19:00 Бямба гараг 9:00-17:00	Хүлээн авах ажлын цагаас бусад үед автомат хариулагчтай холбогдох тул шаардлага болон холбоо барих мэдээллээ үлдээнэ үү
	Утас: 0120-250-169 Ямар хэлээр үйлчилдэг: Хятад хэл	Даваа, Лхагва, Баасан гараг 11:00-19:00	
	Утас: 0120-250-197 Ямар хэлээр үйлчилдэг: Филиппин хэл	Мягмар, Пүрэв гараг 11:00-19:00 Бямба гараг 9:00-17:00	
	Утас: 0120-250-147 Ямар хэлээр үйлчилдэг: Англи хэл	Мягмар, Пүрэв гараг 11:00-19:00 Бямба гараг 9:00-17:00	
	Утас: 0120-250-192 Ямар хэлээр үйлчилдэг: Индонези хэл	Мягмар, Пүрэв гараг 11:00-19:00 Бямба гараг 9:00-17:00	
	Утас: 0120-250-198 Ямар хэлээр үйлчилдэг: Тайланд хэл	Пүрэв гараг 11:00-19:00 Ням гараг 9:00-17:00	
	Утас: 0120-250-366 Ямар хэлээр үйлчилдэг: Канбож хэл	Долоо хоног бүр Пүрэв гараг 11:00-19:00	
	Утас: 0120-250-302 Ямар хэлээр үйлчилдэг: Мьянмар хэл	Долоо хоног бүр Мягмар гараг 11:00-19:00	
Эх хэл дээрх лавлагаа (цахим шуудан)	Ямар хэлээр үйлчилдэг: Вьетнам хэл Хятад хэл Филиппин хэл Англи хэл Индонези хэл Тайланд хэл Камбож хэл Мьянмар хэл	Хэдийд ч хамаагүй	- Хариултыг дараачийн өдрөөс хойш - Агуулгаас хамаарч хүлээлгэх магадлалтай
Эх хэл дээрх зөвлөгөө (Zoom)	Ямар хэлээр үйлчилдэг: Вьетнам хэл Хятад хэл Филиппин хэл Англи хэл Индонези хэл Тайланд хэл Камбож хэл Мьянмар хэл	Зөвлөгөөний огноо, цагийг мэйлээр зохицуулна (Эх хэл дээрх зөвлөгөө (утас) авах боломжтой өдрүүдийн нэг)	- Вэб камерыг унтараасан дуут дуудлага ашиглах болно.
Эх хэл дээрх лавлагаа (Захидал)	Support Division Guidance and Support Department Organization for Technical Intern Training 3F LOOP-X Bldg.,3-9-15 Kaigan, Minato-ku, Tokyo108-0022	Хэдийд ч хамаагүй (Зөвхөн шуудангаар хүлээж авна)	- Хариултыг дараачийн өдрөөс хойш - Агуулгаас хамаарч хүлээлгэх магадлалтай
Байгууллагын лавлах газар (уулзалт, утас, Zoom)	**Орон нутгийн оффис, салбарууд дахь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх хэлтэс (Дэмжлэг үзүүлэх ажил хариуцсан)** (114-р хэсгийг үзнэ үү) Үйлчилгээ үзүүлэх хэл: Япон хэл (шаардлагатай тохиолдолд эх хэл дээрх орчуулагчтай байна)	Долоо хоног бүр Даваа-Баасан гараг 9:00-17:00	- Орчуулагч авах боломжтой (зохицуулалт хийхэд цаг шаардагдах магадлалтай. Ирэхээс өмнө утсаар асуувал илүү үр дүнтэй болно) -Zoom ээр холбогдохыг хүсвэл, урьдчилан орон нутгийн газар, салбартай зөвлөлдөнө үү

窓口名（方法）	連絡先・対応言語	受付時間（毎週）		備考
母国語相談ホットライン（電話）	**電話:0120-250-168** 対応言語：ベトナム語	月曜日～金曜日	午前11:00～午後7:00	受付時間外は留守番電話につながりますので用件と連絡先を残して下さい。
		土曜日	午前 9:00～午後5:00	
	電話:0120-250-169 対応言語：中国語	月曜日・水曜日・金曜日	午前11:00～午後7:00	
	電話:0120-250-197 対応言語：フィリピン語	火曜日・木曜日	午前11:00～午後7:00	
		土曜日	午前 9:00～午後5:00	
	電話:0120-250-147 対応言語：英語	火曜日・木曜日	午前11:00～午後7:00	
		土曜日	午前 9:00～午後5:00	
	電話:0120-250-192 対応言語：インドネシア語	火曜日・木曜日	午前11:00～午後7:00	
		土曜日	午前 9:00～午後5:00	
	電話:0120-250-198 対応言語：タイ語	木曜日	午前11:00～午後7:00	
		日曜日	午前 9:00～午後5:00	
	電話：0120-250-366 対応言語：カンボジア語	毎週木曜日	午前11:00～午後7:00	
	電話：0120-250-302 対応言語：ミャンマー語	毎週火曜日	午前11:00～午後7:00	
母国語相談（メール）	対応言語：ベトナム語 中国語 フィリピン語 英語 インドネシア語 タイ語 カンボジア語 ミャンマー語	いつでも		・回答は翌日以降 ・内容により時間をいただく場合があります。
母国語相談（Zoom）	対応言語：ベトナム語 中国語 フィリピン語 英語 インドネシア語 タイ語 カンボジア語 ミャンマー語	メールで相談日時を調整 （母国語相談（電話）の対応日のいずれか）		・ウェブカメラをオフにした状態で音声通話のみで実施します。
母国語相談（手紙）	〒108-0022 東京都港区海岸3-9-15 LOOP-X 3階 外国人技能実習機構 指導援助部　援助課	いつでも （郵送受付のみ）		・回答は翌日以降 ・内容により時間をいただく場合があります。
機構窓口（面談・電話・Zoom）	**地方事務所・支所の援助課又は指導課(援助担当)** **(115ページ参照)** 対応言語：日本語（必要に応じて母国語の通訳人）	毎週 月曜日～金曜日 午前9:00～午後5:00		・通訳人の手配を希望することもできます（手配にはお時間をいただく場合もあります。可能であれば、来所前に御連絡いただけるとスムーズです。）。 ・Zoomを希望する場合は、事前に地方事務所・支所にご相談ください。

*1. Дээрх өдөр нь амралтын өдөр ба жилийн сүүлийн ба эхний өдөр (12/ 29-1/3) бол эх хэл дээрх лавлах ажиллахгүй болно.
2 Үйлчилгээ үзүүлэх хэл ба ажиллах өдрийн шинэчилсэн мэдээллийг дараах вэб сайтаас үзнэ үү:

"Байгууллагын вэб сайт, эх хэл дээрх сайт"
https://www.support.otit.go.jp/soudan/en/

3. Ур чадварын дадлагажигчийн SOS, яаралтай зөвлөгөө өгөх тусгай лавлах
Та "зодуулах", "нутаг буцаах арга хэмжээ авагдах", "ажил эрхлэгчийн бэлгийн дарамтад өртөх" зэрэг саналт зовоосон асуудалтай байна уу? Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага (OTIT) нь ур чадварын дадлагажигч та бүхнийг эх хэлээр зөвлөгөө өгч дэмждэг. Саналт зовоосон асуудлаа хурдан шийдвэрлэхийн тулд, нэрэлхэлгүй бидэнтэй холбоо барина уу.
Үнэгүй дуудлага хийнэ.
Дээрх утасны дугаар руу залгаж, автомат дуудлагын дараа нь "1" товчийг дарна уу. Та тусгай лавлахтай холбогдох болно.
4. Зөвлөгөөний агуулгаас хамааран, таныг холбогдох байгууллагын холбоо барих цонхтой холбож өгнө.

14. Таны зүгээс хийж болох "мэдүүлэг"-ийн тухай

Ур чадварын дадлагажигч нь ур чадварын дадлагажигчийн тухай хууль гэх мэтийг зөрчсөн үйлдэлтэй тулгарвал (1) Ур чадварын дадлагажигчийн тухай хуульд үндэслэн мэдэгдэх, (2) Хөдөлмөрийн стандартын тухай хуульд үндэслэн мэдэгдэх гэсэн 2 аргаар холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой.

(1) Ур чадварын дадлагын тухай хуульд үндэслэсэн мэдүүлэг

1. Дадлага хэрэгжүүлэгч газар, хянагч байгууллага болон тэдгээрийн удирдах албан тушаалын болон ажилтан нар ("дадлага хэрэгжүүлэгч нар" гэнэ) энэхүү хууль болон түүнд суурилсан захирамж тогтоолыг зөрчвөл ур чадварын дадлагажигч нь энэ талаар Хилийн шалган нэвтрүүлэх , оршин суух хяналтын газрын дарга болон Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад мэдүүлэх боломжтой.
мэдэгдэнэ.
2. Дадлага хэрэгжүүлэгч газар нь өмнө нь мэдүүлэг өгч байснаас болж ур чадварын дадлагажигчийн дадлага ажлыг зогсоох болон бусад ялгаварлан гадуурхах үйлдлийг хийхийг хориглоно.

(Ур чадварын дадлагын тухай хууль 49-р зүйл)

Ур чадварын дадлагажигч нь ур чадварын дадлагажигчийн тухай хуульд үндэслэн, өөрийн дадлага хийж буй компани, нийгэмлэгийн хууль бус үйлдлийг Хилийн шалган нэвтрүүлэх газрын ерөнхий дарга, Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад мэдэгдэл гаргаж болно. Мөн, мэдэгдлийг төлөөлөгчөөр дамжуулан хүргэж болно.
Дараах тохиолдолд Ур чадварын дадлагын хуулийг зөрчсөн болно:

Хууль зөрчсөн жишээ

- Хүч хэрэглэх болон заналхийлэх аргаар ур чадварын дадлагажигчийг дадлага хүчээр хийлгэх
- Ур чадварын дадлагын агуулга хөдөлмөрийн гэрээтэй зөрчилдөх
- Аялалын тасалбар болон оршин суух үнэмлэхийг хадгалах нэрийдлээр авах
- Гадагш гарахыг зүй бусаар хязгаарласан
- Өөрийн хувийн амьдралын эрх чөлөөг зүй бусаар хязгаарласан байх



※1 上記曜日が、祝日及び年末年始（12月29日～1月3日）である場合、母国語相談はお休みです。
2 最新の対応言語と曜日については、下記の機構ホームページで確認をしてください。

【機構ホームページ　母国語相談サイト】
https://www.support.otit.go.jp/soudan/en/

3 技能実習SOS・緊急相談専用窓口

「殴られている」「強制的に帰国させられる」「事業主からセクハラを受けている」など、悩んだり、困っていませんか？外国人技能実習機構（OTIT）では、そのような技能実習生の皆さんを母国語でサポートします。悩みや困りごとを迅速に解決するために、ためらわずに相談してください。

通話料は無料です。
上記電話番号にダイヤル後、自動音声アナウンスのあと「１番」をプッシュしてください。専用の窓口に繋がります。

4 相談の内容に応じて、関係機関の窓口を御案内することがあります。

14. あなたがすることができる「申告」について

技能実習生は、技能実習法等に違反する行為に遭遇した際に、（1）技能実習法に基づく申告、（2）労働基準法等に基づく申告の2種類の方法により、関係機関に対して申告することができます。

(1) 技能実習法に基づく申告

1　実習実施者若しくは監理団体又はこれらの役員若しくは職員（次項において「実習実施者等」という。）がこの法律又はこれに基づく命令の規定に違反する事実がある場合においては、技能実習生は、その事実を出入国在留管理庁長官及び厚生労働大臣に申告することができる。
2　実習実施者等は、前項の申告をしたことを理由として、技能実習生に対して技能実習の中止その他不利益な取り扱いをしてはならない。

（技能実習法第 49 条）

技能実習生は、技能実習法に基づき、自ら実習実施者、監理団体等の不法行為を出入国在留管理庁長官及び厚生労働大臣に対して申告することができます。また、申告は委任状を提出した代理人を通じて行うこともできます。

技能実習法令に違反する行為の例としては次のようなものがあります。

違反例

- 暴行や脅迫等の手段で技能実習を強制されている
- 技能実習の内容が労働契約と相違している
- 旅券や在留カードを保管するといって取り上げられている
- 外出を不当に制限されている
- 私生活の自由を不当に制限されている



Ур чадварын дадлагын хуулийг зөрчсөн талаарх мэдүүлгээ эх хэл дээр үйлдэх бол байгууллагын орон нутаг дахь оффис эсвэл байгууллагаас явуулах эх хэл дээрх зөвлөгөө өгөх лавлагааны газраар (утас, цахим шуудангаар (42-р хуудсыг үзнэ үү)) дамжуулж болно.

Мөн, мэдүүлэг өгснөөр өөрийгөө ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхагдах бий хэмээн санаа зовж байж магадгүй, гэвч хуулиар ур чадварын дадлагажигч мэдүүлэг өгсөнөөр шалтаглан ялгаварлан гадуурхахыг хориглох ба үүнийг зөрчсөн тохиолдолд шийтгэлтэй учир эргэлзэлгүйгээр холбоо барина уу.

Хэрэв мэдүүлэг болон хүлээн авахгүй бол хууль тогтоомж зөрчсөн зэргээр мэдээлэл болгон хүлээн авна.

“Байгууллагын вэб сайт: эх хэл дээрх зөвлөгөө өгөх сайт”
https://www.support.otit.go.jp/soudan/en/

(2) Хөдөлмөрийн стандартын хууль зэрэгт үндэслэн мэдүүлэх нь

1. Ажлын байранд энэхүү хууль болон түүнд үндэслэгдсэн захирамжийг зөрчсөн нь үнэн бол хөдөлмөр эрхлэгч нь бодит байдлыг засгийн газар болон Хөдөлмөрийн стандартын хяналтын албанд мэдүүлж болно.
2. Өмнөх мэдүүлгээс болж ажил олгогч нь хөдөлмөр эрхлэгчийг ажлаас халах эсвэл бусад аргаар ялгаварлан гадуурхаж үл болно.

(Хөдөлмөрийн стандартын тухай хууль 104-р зүйл)

Ур чадварын дадлагажигчид Хөдөлмөрийн стандартын тухай хууль хамаарах учир Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн дагуух мэдүүлэг өгч болно.

Таны ур чадвараа дээшлүүлж байгаа газар дараах зүйл гарвал Хөдөлмөрийн стандартын хяналтын албанд мэдүүлэг өгч болно.

Хэргийг мэдээлэх

- Хөдөлмөрийн гэрээ болон хөдөлмөрийн нөхцөлийн талаархи мэдэгдэлд заасан цалин хөлс төлөгдөөгүй байх
- Илүү цагаар ажилсныг үл харгалзан илүү цагийн мөнгө олгогдоогүй байх
- Бодит байдал дээр илүү цаг ажилласан хэдий ч цагийн бүртгэлийн цаасан дээр буугаагүй байх
- Амралтын цаг байхгүй
- Жил бүрийн ээлжийн цалинтай амралтаа авч чадахгүй байх

Ур чадварын дадлагын тухай хуулийн мэдүүлэгтэй адил Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн дагуух мэдүүлэг өгөхөд ялгаварлан гадуурхах нь хориотой тул эргэлзэлгүйгээр мэдүүлэг өгнө үү.

“Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яамны вэб сайт”
https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudoukijun/kijyungaiyou/kijyungaiyou06.html

技能実習法令違反についての申告を母国語で行おうとする場合、機構の地方事務所又は機構本部が実施する母国語相談窓口（電話、メール（43ページ参照））を通じて行うことができます。

また、申告したことを理由に、自分が不利益を被るのではないかと心配になるかもしれませんが、法律では技能実習生が申告したことで不利益な取扱いをすることを禁止していますし、これに違反した場合の罰則も規定されていますので、ためらうことなく連絡してください。

なお、申告として受付できない場合でも、法令違反に関する情報提供として扱います。

【機構ホームページ　母国語相談サイト】
https://www.support.otit.go.jp/soudan/en/

(2) 労働基準法等に基づく申告

1　事業場に、この法律又はこの法律に基いて発する命令に違反する事実がある場合においては、労働者は、その事実を行政官庁又は労働基準監督官に申告することができる。
2　使用者は、前項の申告をしたことを理由として、労働者に対して解雇その他不利益な取扱をしてはならない。

（労働基準法第 104 条）

技能実習生には労働基準法等も適用されますので、労働基準法等に規定されている申告をすることもできます。

あなたが従事している技能実習において、以下のようなことがある場合は、労働基準監督署に申告することができます。

申告事例


- 雇用契約書及び雇用条件書で示されている賃金が支払われていない
- 残業したにもかかわらず、残業代を支払ってもらえない
- 実際に残業しているにもかかわらず、残業がないようにタイムカードを打刻するよう指示されている
- 休憩時間がない
- 年次有給休暇を取らせてもらえない

また、労働基準法の申告も、技能実習法の申告と同様に申告したことで不利益な取扱いをすることは禁止されていますので、ためらうことなく申告してください。

【厚生労働省　ホームページ】
https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudoukijun/kijyungaiyou/kijyungaiyou06.html

15. Хөдөлмөрийн холбоотой хууль тогтоомжид хамаарах нь

Та (Ур чадварын дадлагажигч) дадлага хэрэгжүүлэгч газартай байгуулсан хөдөлмөрийн хүрээнд Японы Хөдөлмөрийн стандартын хуулиар хамгаалагдаг.



(1) Хөдөлмөрийн гэрээ

А. Хөдөлмөрийн гэрээний харилцаа тогтоох



- Хөдөлмөрийн гэрээ байгуулах үед ажил олгогч нь хөдөлмөрийн нөхцлийг бичгээр үйлдэх үүрэгтэй ба (ажилтан хүссэн тохиолдолд, факс ба и-мэйл, SNS зэргээр илэрхийлж болно.) түүний тулд хөдөлмөрийн нөхцлийн бичгийг бэлдэж, хавсаргасан байдаг.
  Хөдөлмөрийн нөхцлийн бичигт дараах зүйлс багтана.
  i. Хөдөлмөрийн гэрээний хугацаа
  ii. Ажлын (ур чадварын дадлага) байр
  iii. Хүлээх ёстой үүрэг (ажлын төрөл ба гүйцэтгэх ажил)
  iv. Ажил эхлэх ба дуусах цаг, ажлын цагаас хэтэрсэн хөдөлмөр бий эсэх, завсарлагааны цаг, бүх нийтийн амралтын өдөр, ээлжийн амралт зэрэгтэй холбоотой зүйлс
  v. Цалин (үндсэн цалин, ажлын цагаас гадуурх илүү цалингийн хувь)
  vi. Ажлаас гарахтай холбоотой зүйлс
- Хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа хөдөлмөрийн нөхцлийн бичигт заасан хөдөлмөрийн нөхцлийг давтан шалгаж гэрээгээ баталгаажуулах хэрэгтэй.
- Ялангуяа цалингийн тухайд Японд сар бүрийн цалингаас татвар суутгадаг тул өөрийн гар дээр авах цалингийн дүнгээ шалгадаг байгаарай. (66 хуудсыг үзнэ үү)
- Та дадлага хэрэгжүүлэгч газраас хөдөлмөрийн гэрээ болон хөдөлмөрийн нөхцлийн бичгийг авч, заавал өөртөө чухалчлан хадгална уу. (134-р хэсгийг үзнэ үү)

Б. Ажлаас халах

- Ажлаас халах гэдэг нь ажил олгогч болох дадлага хэрэгжүүлэгч газрын зүгээс хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгохыг хэлнэ.
- Та ажил хийж байх хугацаанд дадлага хэрэгжүүлэгчийн зүгээс зайлшгүй гэсэн тохиолдол байхгүй бол гэрээ хэрэгжих зуур ажлаас халагдах боломжгүй юм.
- Хэрвээ зайлшгүй шалтгаанаар ажлаас халах бол:
  - Хамгийн доод тал нь 30 хоногийн өмнө мэдэгдэх ёстой
  - 30 өдрийн өмнө урьдчилан мэдэгдэлгүй ажлаас халсан тохиолдолд ажлаас гарах өдөрт тохирсон ажлаас гарах мэдэгдлийн нөхөн олговор авах ёстой.

Таны өөрийн хариуцлагаас болж нутаг буцаахаас өөр аргагүйд хүрч, ажлаас халагдах бол, хөдөлмөрийн стандартын хяналтын албаны даргын итгэмжлэлийг авсан үед мэдэгдэл болон мэдэгдлийн нөхөн олговор хэрэггүй байж болно.

- Дараах байдлаар ажлаас халахыг хориглоно:
  - Ажлаа хийх явцад гэмтэл өвчнөөс болон амрах хугацаанд, түүнээс хойшхи 30 хоногийн хугацаанд ажлаас халах
  - Хөдөлмөрийн стандартын хяналтын албанд мэдүүлэг өгснөөс болж ажлаас халах
- Ажлаас халагдах тухай мэдээ хүлээн авч, хэрвээ үүнд сэтгэл хангалуун биш байвал

15. 労働関係法令に関すること

あなた（技能実習生）には、実習実施者との労働関係の下、日本の労働基準法が適用され、法的に保護されています。その中の基本的で特に重要なものを、次の(1)から(4)で説明します。



(1) 労働契約

A 労働契約の締結



○労働契約の締結の際には、使用者は労働条件を書面で明示する義務があり（労働者が希望した場合は、FAXや電子メール、SNS等でも明示することができる。）、そのため雇用条件書が作成・交付されています。
雇用条件書には、以下の事項などが記されています。
①労働契約期間
②就業（技能実習）の場所
③従事すべき業務（職種及び作業）の内容
④始業・終業の時刻、所定労働時間を超える労働の有無、休憩時間、休日、休暇等に関することなど
⑤賃金（基本賃金、所定時間外等の割増賃金率）
⑥退職に関する事項
○労働契約の締結に際しては、雇用条件書に記載されている労働条件を確認の上締結してください。
○特に、賃金については、日本では、毎月の支払総額から税金などが差し引かれますので、自分が実際に受け取る金額を確認するようにしてください。（67ページ参照）
○あなたは、実習実施者から雇用契約書及び雇用条件書をもらい、必ず自ら大切に保管してください。（134ページ参照）

B 解雇

○解雇とは、使用者である実習実施者からの申出による一方的な雇用契約の終了をいいます。
○あなたが雇用されている期間中、実習実施者は、やむを得ない事由がある場合でなければ、その契約の途中で解雇することはできません。
○また、やむを得ず解雇する場合であっても、
- 少なくとも30日前までの予告が必要です。
- 30日前での予告を行わないで解雇する場合、解雇までの日数に応じた解雇予告手当の支払いが必要です。

なお、あなたの責めに帰すべき事由によって解雇される場合で、労働基準監督署長の認定を受けているときには予告や予告手当は必要とされないことがあります。

○次のような解雇は禁止されています。
- 業務上の傷病により休業する期間及びその後の30日間の解雇
- 労働基準監督署に申告したことを理由とする解雇

байгууллагад хандан зөвлөгөө авна уу

Түүнчлэн ажлаас халагдах болсон бол таны зүгээс хүсэлт байгаа бол хэрэгжүүлэгчийн зүгээс захидлаар ажлаас халах болсон учир шалтгааныг тодорхой мэдэгдэхгүй бол болохгүй.

(2) Ажлын цаг болон амралтын цаг, бүх нийтийн амралтын өдөр

i. Ажлын цаг болон амралтын цаг, амралтын зарчим



- Хөдөлмөрийн стандартын тухай хуулиар нэг долоо хоногт 40 цаг, 1 өдөрт 8 цагаас хэтэрсэн хөдөлмөр хийж болохгүй (хуулиар тогтоосон ажлын цаг) Түүнчлэн байнгын чухал нөхцлийн дор энэ зарчимд хамаарахгүй өөрчлөгдөж болох ажлын цагаар ажиллуулж болно.
- 6 цагаас илүү ажилвал 45 минут, 8 цагаас илүү ажилвал 60 минутын амралтыг ажлын цагийн дундуур ёстой.
- Хамгийн багадаа долоо хоног бүр 1 өдрийн ажлын өдөр, 4 долоо хоногт 4 өдрөөс дээш амралтын өдөр олгохгүй бол болохгүй (хуулиар тогтоосон амралтын өдөр).
- Газар тариалан, загас агнуурын салбарын хувьд ажиллах цаг, завсарлага, амрах өдрийн тухай журам хамаарахгүй ч, ур чадварын дадлагажигч нь Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн стандартыг дагаж мөрдөх шаардлагатай.

ii. Тогтоосон цагаас гадуур, бүх нийтийн амралтын өдөр хөдөлмөрлөх нь

- Ажил олгогч нь энэхүү Хөдөлмөрийн Стандартын тухай хуулиар зохицуулж буй ажлын цагаас (хуулиар тогтоосон ажлын цаг) илүү ажиллуулсан бол (илүү цагийн хөдөлмөр) , хуулиар тогтоосон бүх нийтийн амралтын өдөр ажиллуулсан бол (амралтын өдрийн хөдөлмөр) илүү цагаар ажиллуулсан шалтгаан, ажлын төрөл, хугацааг уртасгах боломжтой цаг зэргийн талаар ажлын байран дахь ажилчдын дийлэнхийг төлөөлөх төлөөлөгчтэй (ажилчдын дийлэнхээс бүрдэх хөдөлмөрийн холбоо байвал тэрхүү холбоо) хөдөлмөрийн менежментийн гэрээ байгуулан, засаг захиргааны Хөдөлмөрийн стандартын хяналтын албаны тэргүүнд мэдүүлнэ.

iii. Илүү цагийн, бүх нийтээр амралтын өдөр, шөнийн ээлжийн нөхөн олговор

- Ажил олгогч нь ажилчдад хуулиар тогтоосон цагаас илүү хөдөлмөр (илүү цагаар ажиллуулах) эрхлүүлсэн тохиолдолд нөхөн олговор олгох ёстой.

i. Хуулиар тогтоосон ажлын цагаас илүү цагаар ажиллуулсан цагийг (илүү цагийн ажил) энгийн цалингийн 25%-с дээш хувиар тооцно.
ii. Хуулиар тогтоосон бүх нийтийн амралтын өдөр ажиллуулсан цагийг (бүх нийтийн амралтын өдрийн ажил) энгийн цалингийн 35%-с дээш хувиар тооцно.
iii. Оройны 10 цагаас өглөөний 5 цаг хүртэл шөнө ажиллуулсан цагийг (шөнийн ажил) энгийн цалингийн 25%-с дээш хувиар тооцно.

● Тухайлбал, хуулиар тогтоосон ажлын цагаас гадуурх хөдөлмөр нь шөнийн ажил байвал (i.+iii.) олгогдох цалин нь 50%-с дээш хувиар тооцогдоно.

*Нэг сарын турш 60 цагаас илүү ажиллуулсан тохиолдолд илүү цагийн хөлс дээр 50%-с дээш хувийн нөхөн олговор олгоно.

(3) Жил бүрийн ээлжийн цалинтай амралт

Ажил хийж эхлэснээс хойш 6 сараас дээш хугацаанд тасралтгүй ажиллаж, нийт ажлын өдрийн 80%-с дээш ажилсан бол тухайн ажилтан нь 10 хоногийн жил бүрийн ээлжийн цалинтай амралт авах эрхтэй. Үүнээс хойш, 1 жил тутамд авах ээлжийн цалинтай амралтын өдрийн тоо нэмэгдэнэ.

Ажилласан жил	6 сар	1 жил 6 сар	2 жил 6 сар	3 жил 6 сар	4 жил 6 сар	5 жил 6 сар	6 жил 6 сараас дээш
Амрах өдрийн тоо	10 өдөр	11 өдөр	12 өдөр	14 өдөр	16 өдөр	18 өдөр	20 өдөр

○仮にあなたが解雇すると告げられ、納得できない場合には、機構に相談しましょう。
なお、仮に解雇されることになった場合、あなたから請求があれば、使用者は書面にて解雇の理由を明らかにし交付しなければなりません。

(2) 労働時間と休憩・休日

①労働時間と休憩・休日の原則



- 労働基準法では、原則として、週40時間、1日8時間を超えて労働させてはなりません（法定労働時間）。
  なお、一定の要件の下で、この原則によらない変形労働時間制を採用することができます。
- 労働時間が6時間を超える場合は45分、8時間を超える場合は60分の休憩を労働時間の途中に与えなければなりません。
- 少なくとも毎週1日の休日か、4週間を通じて4日以上の休日を与えなければなりません（法定休日）。
- 農業や水産業の分野では、労働時間や休憩・休日の規定の適用はありませんが、技能実習生については労働基準法の基準に準拠することとされております。

②時間外労働・休日労働

- 使用者が、この労働基準法で定められた労働時間（法定労働時間）を超えて労働させる場合（時間外労働）、または法定休日に労働（休日労働）させる場合には、時間外労働をさせる事由、業務の種類、延長することができる時間等について、事業場の労働者の過半数を代表する者（労働者の過半数で組織する労働組合がある場合は、その労働組合）と労使協定を締結し、所轄の労働基準監督署長に届け出ておかなければなりません。

③時間外・休日・深夜割増賃金

- 使用者が労働者に法定時間外労働（残業）をさせた場合などには、割増賃金を支払わなければなりません。

①法定労働時間を超えて働かせた時間（時間外労働）は通常賃金の25%以上増し
②法定休日に働かせた時（休日労働）は通常賃金の35%以上増し
③午後10時から午前5時までの深夜に働かせた時（深夜労働）は通常賃金の25%以上増し

●例えば、法定労働時間外の労働かつ深夜労働であった場合（①+③）は、支給される賃金は50%以上増えます。

※1か月の間に60時間を超えて時間外労働をさせた場合には、その超えた時間の労働について50%以上の割増賃金を支払わなければなりません。

(3) 年次有給休暇

雇用開始後６か月以上継続して勤務し、全労働日の８割以上出勤した労働者には、10日間の年次有給休暇を取得する権利が与えられます。その後、１年ごとに取れる休暇日数は増えていきます。

勤務年数	6か月	1年6か月	2年6か月	3年6か月	4年6か月	5年6か月	6年6か月
付与日数	10日	11日	12日	14日	16日	16日	20日

Журмын ээлжийн цалинтай амралт авахад амрах эсвэл аялах зорилгоор амрах болсныг лавлахгүй, ажил эрхлэгчийн хүссэн улиралд амралтаа авах хүсэлт гаргах эрхтэй. Гэвч, амралт авахыг хүссэн тухайн хугацаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол ээлжийн цалинтай амралтын өдрүүдийг өөрчлөх тохиолдол байж болно.

Энэхүү жил бүрийн ээлжийн цалинтай амралтыг ажил олгогч нь худалдаж авахыг хориглоно.



*2019 оны 4-р сараас эхлэн жилд 10-с дээш хоног жил бүрийн ээлжийн цалинтай амралт авах ажилтанд жил бүрийн ээлжийн цалинтай амралтын 5 хоногийг (ажилтны аль хэдий нь авсан ээлжийн амралт, амралт авахаар мэдүүлсэн өдрийг оруулаагүй) ажил олгогч нь улирлаар тогтоож олгох үүрэгтэй болсон. Ажил олгогч нь улирлын чанартай ажлын тухайд, ажилчдынхаа санал бодлыг сонсож, ажилчдынхаа ээлжийн цалинтай амралт авах хүсэлтийг аль болох биелүүлэхийг чармайх ёстой.

(4) Цалин

• Цалин олгох арга

- Ажил олгогч нь цалин олгохдоо, i.мөнгөн дэвсгэртээр ii. нийт дүнг iii. сар бүр нэгээс дээш удаа iv. тогтсон өдөрт v. тухайн хүнд шууд цалин олгоно
  Гэхдээ хөдөлмөр эрхлэгч өөрөө хүлээн зөвшөөрвөл, мөнгөн дэвсгэртээр бус, ажилчны өөрийн нэр дээрхи банкны данс руу шилжүүлж болно. Гэвч , бансны дансаар шилжүүлэх бол, дараахь нөхцлийг бүгдийг хангах ёстой.
  i. Тухайн хүний бичгээр үйлдсэн зөвшөөрөлтэй бол
  ii. Цалинг цалин олгох тогтсон өдөрт төлдөг байх
  iii. Цалингийн баримт (дэлгэрэнгүй хуудас) гаргаж өгөх
  iv. Банкны дансанд шилжүүлэхтэй холбоотой ажилтан ба ажил олгогч хоорондын гэрээг байгуулах



- Мөн, цалингаас татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ажил эрхлэлтийн даатгалын хураамж зэргийг хуулиар тогтоосны дагуу суутгана. Түүнчлэн урьдчилан хөдөлмөрийн гэрээ байгуулагдсан бол байр хоолны төлбөр болон ус, цахилгаан, хийн төлбөрийг цалингаас шимтгэнэ.

(*) “Цалин тооцох талаарх мэдлэг” (68-р хуудсыг үзнэ үү)

- Харин, хянагч байгууллагын дадлага хэрэгжүүлэгч газраас суутгах хяналтын зардлыг ур чадварын дадлагажигч төлөх ёсгүй тул цалингаас нь суутгаж үл болно.

Хяналтын зардлын талаар (тайлбар)

Хянагч байгууллагын ур чадварын дадлагжигчийг хүлээн авах ажилтай холбогдох ажлыг хэрэгжүүлэхэд зарцуулах зардлыг хэлнэ. Хянагч байгууллага болон дадлага хэрэгжүүлэгч газар эдгээр зардлыг даах тул ур чадварын дадлагажигчийн сургалтын тэтгэлэг болон цалингаас суутгахгүй болно.

• Цалингийн дүн

- Ажил олгогч нь цалингийн хамгийн доод хэмжээний хуулиар нийслэл, хот, мужийн нэгжийн хэмжээнд тогтоосон орон нутаг тус бүрийн хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээ эсвэл тодорхой салбарт хамааралтай хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээнээс дээш дүнг төлөх ёстой.

また、原則として有給休暇は休養のためでもレジャーのためでも利用目的を問われることなく、労働者の請求した時季に取得することができます。ただし、請求された時季に有給休暇を与えることが事業の正常な運営を妨げる場合においては、他の時季に変更される場合があります。

なお、この年次有給休暇を使用者が買い上げることは禁止されています。



※平成31年（2019年）4月から、年10日以上の年次有給休暇が付与される労働者に対し、年次有給休暇のうち年５日（労働者がすでに取得・請求した日数を除く。）については、使用者が時季を指定するなどして取得させることが義務付けられました。使用者は、時季の指定に当たっては、労働者の意見を聴取し、できる限り労働者の希望に添うよう、聴取した意見を尊重するよう努めなければなりません。

(4) 賃金

○賃金の支払い方法

・ 賃金の支払いについて、使用者は、①通貨で②全額を③毎月1回以上④一定の期日を定めて⑤直接本人に支払うことになっています。
ただし、労働者本人が同意すれば、現金ではなく、労働者本人が指定した銀行等の、労働者本人の預金口座又は貯金口座に振り込むことも認められます。なお、口座振込にする場合、以下の条件を全て満たすことが必要です。
①本人の書面による同意を得ること
②賃金支給日として決められた日に払出しができるようにすること
③賃金計算書（明細書）を交付すること
④口座振込に関する労使協定を締結すること



・ また、税金、社会保険料、雇用保険料等は、法令に従い賃金から控除されます。その他、あらかじめ労使協定が締結されている場合は、宿舎費や水道光熱費等も賃金から控除されます。
（※）「賃金計算の知識」（69ページも参照ください。）
・ なお、監理団体が実習実施者から徴収することとなる監理費については、技能実習生が負担すべきものではなく、賃金から控除してはいけないことになっています。

【解説】監理費について

監理団体が技能実習生の受入れに関する業務を実施するための経費のことです。これらは、技能実習生が負担すべき費用ではなく、監理団体や実習実施者が負担するものなので、講習手当や賃金から控除されることはありません。

○賃金額

・ 賃金額については、使用者は最低賃金法により都道府県単位で定められた地域別最低賃金額または特定の産業に適用される特定最低賃金額以上を支払わなければなりません。

Цалингийн доод хэмжээний талаар (тайлбар)

- Цалингийн доод хэмжээ нь орон нутгийн цалингийн доод хэмжээ ба тусгай бүс нутгийн цалингийн доод хэмжээ гэсэн 2 төрөлд хуваагдана. Хоёр төрөлд нэгэн зэрэг хамаарах бол ажил олгогч нь аль илүү их дүнтэй төрлийн цалингийн доод хэмжээний дүнгээс илүү цалин олгохгүй бол болохгүй.
  i. Орон нутгийн цалингийн доод хэмжээ: Аж үйлдвэр болон ажлын төрлөөс үл хамааран нийслэл, хот, мужийн бүх ажилчид болон ажил олгогчдод хамаарах цалингийн доод хэмжээг хэлнэ. 2025 оны 12 сарын байдлаар, Токио хотод 1226 иэн, Кочи муж, Миязаки муж, Окинава мужид 1023 иэн зэргээр.
  ii. Тусгай бүс нутгийн цалингийн доод хэмжээ: Тусгай бүс нутаг дахь тусгай аж үйлдвэрийн ажилчдад хамаарах цалингийн доод хэмжээг хэлнэ.
- Цалингийн доод хэмжээтэй харьцуулах арга:

Цагийн хөлс авдаг бол	Цагийн хөлс ≥ Хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээ (цагаар)
Өдрийн хөлс авдаг бол	Өдрийн хөлс ÷ 1 өдрийн тогтсон ажлын дундаж цаг ≥Хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээ (цагаар)
Сарын хөлс авдаг бол	Сарын хөлс ÷ 1 сарын дундаж тогтоосон ажиллах цаг ≥ цалингийн доод хэмжээ (цагаар)

Нийт орон даяарх цалингийн хамгийн доод хэмжээний талаар дараах вэб сайт болон ойр орчимд байрлах Хөдөлмөрийн стандартын хяналтын албанаас лавлаж болно.

"Цалингийн доод хэмжээний талаар тусгайлан гаргасан Япон хэл дээрх вэб сайт"
https://saiteichingin.mhlw.go.jp/

- Ур чадварын дадлагажигчийн хувьд цалингийн доод хэмжээний тухай хууль болон Хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн дагуу цалингаа бодуулах нь зүй ёсны хэрэг боловч Ур чадварын дадлагын тухай хуулинд "Ур чадварын дадлагажигчийн авах цалин хөлсний дүн Япон хүн ажилсантай ижил буюу түүнээс дээш хэмжээнд байна" хэмээн тогтоосон байна.
- Илүү цагийн, бүх нийтийн амралтын өдрийн нөхөн олговор олгох:
  - Илүү цагаар ажилсан, хуулиар тогтоосон бүх нийтийн амралтын өдөр ажилласан, шөнийн цагаар ажилсан бол (2) iii. "Илүү цагийн, бүх нийтийн амралтын өдрийн нэмүү өртөг"-ийн талаар дурьдсан нэмүү өртөгийн цалинг авна.
- Ажлын цаг, цалин хөлстэй холбоотой эдгээр журмыг зөрчсөн, хөдөлмөрийн нөхцөлд заасан агуулга нь хөдөлмөрийн бодит нөхцөлөөс өөр байвал ур чадварын дадлагажигчийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэрчилгээг хүчингүй болгож, ур чадварын дадлага хэрэгжүүлэх боломжгүй болж магадгүй.
  Иймд ур чадварын дадлагажигчид өөрсдөө Японы хууль тогтоомжийг бүрэн ойлгож, хөдөлмөрийн нөхцлийн агуулгатай өөрийн ажлын нөхцөл нь өөр байвал хянагч байгууллага болон манай байгууллагатай зөвлөлдөх хэрэгтэй.
- Чөлөө авах үед төлөх нөхөн олговор
  - Дадлага хэрэгжүүлэгчийн хариуцлагаас болж чөлөө олгогдох үед, тухайн хугацаанд дундаж цалингийн 60%-аас дээш хэмжээний чөлөөний нөхөн олговорыг танд олгох болно гэж тусгагдсан байна.
- Төлөгдөөгүй цалинг өмнөөс нь төлөх
  - Дадлага хэрэгжүүлэгч газар дампуурсны улмаас цалингаа авалгүйгээр ажлаасаа гарсан ажилчны хувьд цалингийн төлбөрийг хангах хуулинд үндэслэн төлөгдөөгүй байгаа цалингийн нэг хэсгийг өмнөөс нь төлөх тогтолцоо бий. Энэхүү тогтолцоогоор ямар нөхцлийн дор цалин олгогддог мөн хэмжээний талаар хамгийн ойр байрлах нийслэл, хот, мужийн Хөдөлмөрийн товчооны харьяа Хөдөлмөрийн стандартын хэлтэс, Хяналтын хэлтэс болон Хөдөлмөрийн стандартын хяналтын албанаас лавлана уу.
- Хууль тогтоомжоор хориглосон бусад зүйлс
  Дараах зүйлс нь Хууль тогтоомжоор хориглосон байна:
  i. Хөдөлмөрлөж төлнө гэсэн нөхцөлтэйгөөр өмнө зээлсэн мөнгийг цалингаас суутгах
  ii. Хүчээр банкинд мөнгө хадгалуулах
  iii. Ажил олгогч болон хянагч байгууллага нь тухайн хүний нэр дээрх хадгаламжийн дэвтэр зэргийг хураан авч хадгалах

"Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн яам, Хөдөлмөрийн стандартын вэб сайт"
https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudoukijun/index.html

"Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Гадаадын хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан утасны лавлах үйлчилгээ"
Гадаадын иргэдэд зориулсан утасны лавлах үйлчилгээний талаар 100-р хуудаснаас үзнэ үү.

【解説】最低賃金について

○最低賃金には、地域別最低賃金と特定最低賃金の2種類があります。なお、両方が同時に適用される場合には、使用者は高い方の最低賃金額以上の賃金を支払わなければなりません。
①地域別最低賃金：産業や職種にかかわりなく各都道府県の全ての労働者とその使用者に適用される最低賃金です。令和７年（２０２５年）１２月現在、東京都は１，２２６円、高知県、宮崎県、沖縄県は１，０２３円など。
②特定最低賃金：特定地域内の特定の産業の労働者とその使用者に適用される最低賃金です。
○最低賃金額との比較方法

時間給の場合	時間給≧最低賃金額（時間額）
日給の場合	日給÷１日平均所定労働時間≧最低賃金額（時間額）
月給の場合	月給÷1か月平均所定労働時間≧最低賃金額（時間額）

全国の最低賃金については下記のインターネットのホームページ又はお近くの労働基準監督署で確認ができます。

【最低賃金に関する特設サイト（日本語）】
https://saiteichingin.mhlw.go.jp/

○技能実習生に対しては、最低賃金法をはじめ労働関係法令を遵守した賃金の支払を行う必要があることは当然ですが、技能実習法では、「技能実習生に対する報酬の額が日本人が従事する場合の報酬の額と同等以上であること」と定めています。
○時間外・休日割増賃金の支払
・時間外労働、法定休日労働、深夜労働を行った場合には、「(2) ③時間外・休日割増賃金」で述べた割増賃金が支払われます。
○これらの労働時間や賃金に関する規定の違反があったり、雇用条件書に記載されている内容と実際に働いている労働条件が違っていたりする場合、技能実習計画の認定が取り消され、技能実習ができなくなることもあります。
そのため、技能実習生自身も日本の法律をしっかりと理解して、雇用条件書の内容と自分の労働条件が違う場合は、監理団体や機構に相談しましょう。
○休業手当の支払
・実習実施者の責めに帰すべき事由による休業の場合においては、実習実施者は休業期間中、あなたに平均賃金の60%以上の休業手当を支払わなければならないとされています。
○未払賃金の立替払
・実習実施者の倒産により、賃金が支払われないまま退職した労働者に対して、賃金の支払の確保等に関する法律に基づき、未払賃金の一部を立替払する制度があります。この制度で立替払を受けることができる方の要件や対象となる未払賃金などの詳細については、最寄りの都道府県労働局労働基準部監督課又は労働基準監督署にお問い合わせください。
○その他の法令等の禁止事項
以下の事項が法令等で禁止されています。
①労働することを条件とする前貸の債権と賃金の相殺
②強制預金を行うこと
③使用者や監理団体が本人名義の預金通帳等を預かること

【厚生労働省　労働基準ホームページ】
https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/koyou_roudou/roudoukijun/index.html

【厚生労働省　外国人労働者向け相談ダイヤル】
101ページを御覧ください。



16. Нийгмийн даатгал

Нийгмийн даатгал гэдэг нь өвчин тусах, гэмтэж бэртэхэд гарсан эмчилгээний зардал болон өвчин, гэмтлийн улмаас нас барсан, нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд тэтгэвэрийн төлбөрөөр дамжуулан даатгал төлөгч болон түүний гэр бүлийн амьдралын баталгаа гаргах улсын тогтолцоог хэлнэ.

Нийгмийн даатгалд хамрагдах болон даатгалын шимтгэл төлөх нь заавал биелүүлэх үүрэг юм. Даатгалд хамрагдсанаар та (ур чадварын дадлагажигч) даатгалын шимтгэл төлөх шаардлагатай боловч, та (ур чадварын дадлагажигч) Япон улсад асуудал хүндрэлтэй учирсан үед даатгалын тэтгэмж зэрэг дэмжлэг авах боломжтой. Хэрэв ойлгомжгүй зүйл байвал, оршин суугаа хот, дүүрэг, сумын хариуцсан үйлчилгээний цонх эсхүл өөрт ойрхон тэтгэврийн албанд хандан зөвлөгөө авна уу.

[Японы тэтгэврийн албаны вэб сайт　Гадаад иргэдэд зориулсан/International]
https://www.nenkin.go.jp/international/index.html

(1) Нийгмийн даатгалын төрөл ба төлбөр

	Төрөл	Төлбөр
Эмчилгээний даатгал	Эрүүл мэндийн даатгал Улсын эрүүл мэндийн даатгал	• Өвчин болон гэмтлээс үүдэн гарсан эмчилгээний зардлын нэг хэсгийг (70 нас хүртэл 70%) даатгалаар төлнө (өөрийн зүгээс гаргах эмчилгээний зардал нь 30% болно).Даатгалд хамрагдсан эмнэлгийн үйлчилгээ авахын тулд, хувийн эрүүл мэндийн даатгалын үнэмлэх (*) эсхүл даатгалын эрхийн баталгааны үнэмлэх шаардлагатай. Эмнэлгийн хүлээн авах хэсэгт үзүүлнэ үү. Харин ажилтай холбоотойгоор үүссэн осол, өвчин болон ажилдаа ирэх, буцах замд гарсан осол гэмтэлд Хөдөлмөрийн гэнэтийн ослын нөхөн төлбөр олгоно. Энэ тохиолдолд эмчилгээний зардлын бүх дүнг Хөдөлмөрийн гэнэтийн ослын даатгалаас төлнө.
Тэтгэвэр	Нийгмийн халамжийн тэтгэвэр Улсын тэтгэвэр	• Хөгшрөх, хөгжлийн бэрхшээл, нас барахтай холбогдуулан шаардлагатай төлбөрийг (тэтгэвэр олгох) олгоно.

•Та (Ур чадварын дадлагажигч) “Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн халамжийн тэтгэвэр” эсвэл “Улсын эрүүл мэндийн даатгал болон улсын тэтгэвэр” багцын аль нэгэнд нь хамрагдах ёстой.
• “Япон улсад ирсний дараа сургалтын хугацаанд”, та (ур чадварын дадлагажигч) нь “Улсын эрүүл мэндийн даатгал болон улсын тэтгэвэр” - т хамрагдана. Даатгалд хамрагдахтай холбоотой бүрдүүлэлтийг та (ур чадварын дадлагажигч) өөрөө хийнэ. Та (ур чадварын дадлагажигч) оршин суугаа хот, дүүрэг, сумын хариуцсан үйлчилгээний цонхонд очиж бүрдүүлэлтээ хийнэ үү. Хэрэв энэхүү бүрдүүлэлттэй холбоотойгоор ойлгомжгүй зүйл байвал, хянагч байгууллага эсхүл ажил олгогч (дадлага хэрэгжүүлэгч) - той зөвлөлдөнө үү.
• “Дадлагын хугацаанд ” та (ур чадварын дадлагажигч) “Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн халамжийн тэтгэвэр” - т хамрагдана.　Даатгалд хамрагдахтай холбоотой бүрдүүлэлтийг ажил олгогч (дадлага хэрэгжүүлэгч) хийнэ. Та (ур чадварын дадлагажигч) ажил олгогч (дадлага хэрэгжүүлэгч)-ийн зааврын дагуу шаардлагатай бичиг баримтыг бэлтгэнэ үү.

*Нийгмийн даатгалын тогтолцоонд хамрагдсан тохиолдолд, хувийн дугаарын карт дээр эрүүл мэндийн даатгалын үнэмлэхийг ашиглах бүртгэл хийснээр, хувийн дугаарын картыг
эрүүл мэндийн даатгалын үнэмлэх болгож ашиглах боломжтой. Дэлгэрэнгүй 1900. Хувийн дугаарын тогтолцоо болон хувийн дугаарын картаас лавлана уу.

